

**"МОНГОЛ МАЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2010-2015 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТОВЧОО
(2015 оны жилийн эцсийн байдлаар)**

2015 оны 03 дугаар сарын 29

| № | Хөтөлбөр/төслийн агуулга | Гүйцэтгэл | | | |
|---|---|--|---------------------|-----------|------|
| 1 | Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар: УИХ-ын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоол, хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 222 дугаар тогтоолоор тус тус баталсан. | Хөтөлбөрийн зорилго: Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. | | | |
| 2 | Санхүүжилтийн эх үүсвэр | Улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, Иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт | | | |
| 3 | Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам I үе шат 2010–2015 он II үе шат 2015–2021 он | | | |
| 4 | Хөтөлбөрийн зорилт | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Зорилт 1. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ. Зорилт 2. Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ. Зорилт 3. Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөл бүрдэнэ. Зорилт 4. Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуйг зонхилон, эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт хязгаарлагдмал хүрээнд эрхлэн, бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн эрсдэлийг бууруулна. Зорилт 5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлнэ. | | | |
| 5 | Зардал | 2010-2015 он | 273.7 тэрбум төгрөг | | |
| | | Үүнд: | Төсөв (он) | Гүйцэтгэл | Хувь |
| | | Багц 1 | 273.7 | 273.7 | 100 |
| 6 | Хөтөлбөрийн зорилт: | Биелэлт | | | |
| | 1-р зорилт | Биелэлт 5-7 дугаар хуудас | | | |
| | 2-р зорилт | Биелэлт 8-17 дугаар хуудас | | | |
| | 3-р зорилт | Биелэлт 17-28 дугаар хуудас | | | |
| | 4-р зорилт | Биелэлт 28-36 дугаар хуудас | | | |
| | 5-р зорилт | Биелэлт 37-41 дугаар хуудас | | | |

| | | | | | | | | | |
|----|---|----------------|--|-------------|-------------|-------------|-------------|-------------|--|
| 7 | Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | | Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 67.8 хувьтай буюу “Хангалттай” гэж үнэлэгдэж байна. Үүнээс нэг дүгээр тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.0 хувьтай, хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.3 хувьтай, гуравдугаар тэргүүлэх чиглэл 57.8 хувьтай, дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл 60.5 хувьтай, тавдугаар тэргүүлэх чиглэл 72.6 хувийн биелэлттэй байна. Уг хөтөлбөр нь 2021 он хүртэл үргэлжлэх бөгөөд хэрэгжилт удаашралтай болон хэрэгжээгүй арга хэмжээг 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна. | | | | | | |
| 8 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ | | Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, холбоод, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллага, ХААИС-тай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хангалттай ажилласан гэж дүгнэж байна. | | | | | | |
| 9 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт | Биелэлт дундаж | Зорилтын тоо | Зорилт 1 | Зорилт 2 | Зорилт 3 | Зорилт 4 | Зорилт 5 | |
| | | 67.8 | 5 | 74.0 | 74.3 | 57.8 | 60.5 | 72.6 | |
| 10 | Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ) | | Нэгдсэн үнэлгээ | | | | | | |
| | | | ... % | | | | | | |

"МОНГОЛ МАЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2010-2015 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 03 дугаар сарын 29

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2010-2015 оны жилийн эцсийн тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэл, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуурт хамаарах статистик мэдээлэл зэрэг эх сурвалжуудыг ашиглав.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тус хөтөлбөрийг УИХ-ын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор, хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 222 дугаар тогтоолоор тус тус баталсан. Хөтөлбөрт дэвшүүлэн тавьсан 5 тэргүүлэх чиглэлийг хангах зорилгоор нийт 87 арга хэмжээг тусгасан.

Хөтөлбөрийн зорилго:

Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл:

1. Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч, эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчин бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангаж, сайн засаглалыг хөгжүүлэх;

2. Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх;

3. Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;

4. Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх;

5. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОЙМ, ҮР ДҮН

Хөтөлбөрийг 2010-2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан 5 зорилт, 17 чиглэлийн 102 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

| № | Зорилт | Чиглэл | Хэрэгжүүлэх арга хэмжээ |
|------------|--|--|-------------------------|
| 1 | Мал аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | Мал аж ахуйн чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох | 13 |
| | | Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэх | 7 |
| | | Мал аж ахуйн үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | 5 |
| 2 | Малын чанар, үржлийн ажил үйлчилгээг сайжруулах | Малын чанар, ашиг шимийг сайжруулах | 5 |
| | | Малын удмын санг хамгаалах | 5 |
| | | Малын үржлийн ажил үйлчилгээг сайжруулах | 4 |
| | | Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох | 3 |
| 3 | Малын эрүүл мэндийг хамгаалах | Малын гоц халдварт, халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх | 9 |
| | | Мал эмнэлгийн албаны тогтолцоог боловсронгуй болгох | 4 |
| | | Эм, эмнэлгийн хэрэгсэлийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын түвшинд хүргэх | 4 |
| 4 | Байгалийн эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх | Бэлчээрийн менежментийг сайжруулах | 7 |
| | | Хадлан тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх | 8 |
| | | Малын усан хангамжийг сайжруулах | 5 |
| | | Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах чадавхи бий болгох | 5 |
| 5 | Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | Мал, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | 7 |
| | | Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдийн засгийн урамшуулал бий болгох | 2 |
| | | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийг сайжруулах | 9 |
| ДҮН | 5 | 17 | 102 |

Нэг. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

1.1 МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ:

Эрх зүйн таатай орчин бүрдүүлэх чиглэлийн хүрээнд дараах хууль тогтоомжийг боловсруулан, батлуулав. Үүнд:

| № | Батлагдсан огноо | Тушаалын дугаар | Тогтоолын нэр |
|--|------------------|-----------------|---|
| Монгол улсын хууль | | | |
| 1 | 2012.05.17 | | Амьтны тухай /шинэчилсэн найруулга/ |
| 2 | 2011.06.02 | | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай |
| Улсын их хурлын тогтоол | | | |
| 3 | 2011.01.06 | №02 | Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай |
| 4 | 2011.06.02 | №29 | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай |
| 5 | 2011.06.03 | №30 | Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай |
| 6 | 2011.12.23 | №64 | “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлах тухай тогтоолын зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай |
| 7 | 2012.05.18 | №37 | Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай |
| 8 | 2012.09.18 | №37 | Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай |
| 9 | 2012.12.28 | №73 | “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай |
| 10 | 2012.12.28 | №74 | Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай |
| 11 | 2012.05.24 | №39 | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай |
| 12 | 2014.07.01 | №53 | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай |
| 13 | 2015.02.18 | №40 | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай |
| 14 | 2015.11.26 | №104 | Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого |
| Монгол улсын засгийн газрын тогтоол | | | |
| 15 | 2011.01.19 | №10 | Улсын сайн малчин, тэргүүний тариаланч хамт олон шалгаруулах зарим арга хэмжээний тухай |
| 16 | 2011.03.09 | №73 | Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай |
| 17 | 2011.06.22 | №192 | Мал аж ахуйн салбарын 2011-2012 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай |
| 18 | 2011.08.17 | №247 | Журам батлах тухай /Шүлхий өвчнөөр эрүүл-вакцин хэрэглэдэг бүсийн/ |
| 19 | 2012.01.18 | №18 | Улсын сайн малчин, тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланч шалгаруулах зарим арга хэмжээний тухай |
| 20 | 2012.01.30 | №25 | Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Улсын сайн малчин, улсын тэргүүний тариаланч хамт олон, улсын тэргүүний тариаланч шалгаруулах зарим арга хэмжээний тухай/ |
| 21 | 2012.04.11 | №117 | Мал хаваржилт, төл бойжилтын байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай |

| | | | |
|-----------------------------|------------|------|--|
| 22 | 2012.11.03 | №120 | Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай |
| 23 | 2012.12.08 | №158 | Аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай |
| 24 | 2012.07.18 | №239 | Хөдөө аж ахуйн салбарын 2012-2013 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай |
| 25 | 2013.01.12 | №08 | Малчдын хоршоог хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай |
| 26 | 2013.01.12 | №12 | Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон” шалгаруулах/ |
| 27 | 2013.01.12 | №13 | “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон” шалгаруулах тухай |
| 28 | 2013.02.07 | №48 | Журам батлах тухай /арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, хяналт тавих, тайлагнах журам/ |
| 29 | 2013.03.30 | №126 | Ноолуурын салбарт технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх тухай |
| 30 | 2013.04.13 | №141 | Үйлдвэрлэлийг дэмжих тухай |
| 31 | 2013.05.04 | №163 | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай /ЗГ-ын 2013 оны 126, 141-р тогтоолд/ |
| 32 | 2013.07.06 | №249 | Арьс, ширний үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай |
| 33 | 2013.07.09 | №266 | Мал аж ахуйн салбарын 2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай |
| 34 | 2014.01.11 | №5 | Журамд өөрчлөлт оруулах тухай /“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор шалгаруулах/ |
| 35 | 2014.01.11 | №6 | “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-оор шалгаруулах тухай |
| 36 | 2014.03.21 | №87 | Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай |
| 37 | 2014.06.25 | №204 | Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны төсвийн хязгаарыг батлах тухай |
| 38 | 2014.06.28 | №212 | Журам батлах тухай /экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн төслийг санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах/ |
| 39 | 2014.07.28 | №241 | Хөдөө аж ахуйн салбарын 2014-2015 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай |
| 40 | 2014.09.18 | №299 | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай |
| 41 | 2015.03.30 | №122 | Журам шинэчлэн батлах тухай /малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох/ |
| ХХАА-н Сайдын тушаал | | | |
| 42 | 2011.06.02 | A/86 | Өвчний жагсаалт, заавар батлах тухай /хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох мал, амьтны өвчний жагсаалт/ |
| 43 | 2011.05.12 | A/74 | Журам батлах тухай /малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай/ |
| 44 | 2013.02.26 | A/31 | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ тогтоох тухай /Хүнсний бүтээгдэхүүн дах малын эм био бэлдмэлийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ/ |
| 45 | 2013.03.07 | A/35 | Биржээр арилжих барааны жагсаалт, код, коджуулах журам батлах тухай |
| 46 | 2013.08.06 | A/98 | Журам батлах тухай /Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам/ |
| 47 | 2014.08.06 | A/85 | Журам батлах тухай /Мал эмнэлгийн фармакопейн хорооны ажиллах/ |

| | | | |
|----|------------|-------|---|
| 48 | 2015.10.15 | A/123 | Тушаалд өөрчлөлт оруулах тухай /Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын A/142 тушаалд/ |
| 49 | 2015.10.15 | A/124 | 2016 оны эхний хагас жилд экспортлох малын махны нэр төрөл, тоо хэмжээг тогтоох тухай |

- ❖ Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2015 оны 07 дугаар сарын 9-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж, УИХ-ын нэгдсэн чуулганы 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг цаашид “хэлэлцэх эсэх нь” дэмжигдсэн. Иймд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны тогтоолоор ажлын хэсэг байгуулагдан УИХ-ын хаврын чуулганаар хуулийн төслийг хэлэлцүүлэхэд бэлтгэж байна.
- ❖ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хурлаар хэлэлцээр шийдвэрлэсэн. Мөн УИХ-ын БОХХААБХ-ны 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор УИХ-ын ажлын хэсэг болон тус ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг тус тус байгуулагдан ажиллаж байна. Энэ хүрээнд ХХААЯ БОХХААБХ-той хамтран 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр оролцогч талуудын хэлэлцүүлэг зохион байгуулж хуулийн төсөлд санал авсан. Үүний зэрэгцээгээр дэд ажлын хэсэг 6 удаа хуралдаж, тус хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах зарчмын зөрүүтэй саналын томъёолол боловсруулан УИХ-ын ажлын хэсэгт танилцуулаад байна.
- ❖ Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулж, бусад улс орны төрийн дэмжлэгийн чиглэл, туршлагыг судлах ажил хийгдэж байна.
- ❖ Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын 1998 оны А/46 дугаар тушаалаар баталсан “Малын удмын санг хамгаалах ажлыг зохион байгуулах, үр, хөврөл үрийг хадгалах, ашиглах журам”-ыг шинэчлэн “Малын генийн санд генетик нөөцийг байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих тухай” журмын төслийг боловсруулсан. Хууль зүйн яамнаас хуульд тухайн журмын нэрээр Сайдад эрх олгогдоогүй тохиолдолд бүртгэхгүй байх чиглэлийг баримтлаж байгаа тул хуульд өөрчлөлт оруулах хүртэл хугацаагаар батлуулах, Улсын бүртгэлд бүртгүүлэх асуудал нь түр хүлээгдэж байна.

1.2 МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН АНХАН ШАТНЫ НЭГЖИЙГ БЭХЖҮҮЛЭХ:

Монгол улсад 2010 оны байдлаар 788 хувийн мал эмнэлэгт 1319 их, бага эмч ажиллаж нэг нэгжид 52.5 мянга, нэг малын эмчид 31.5 мянган мал ноогдож байсан бол 2015 оны эцэст 960 мал эмнэлэгт 1445 их, бага эмч ажиллаж, нэг нэгжид 51.2, нэг малын эмчид 34.0 мянган мал ноогдож нэгжийн тоо 21.8 хувиар нэмэгдсэн байна. Жил дараалан мал сүрэг өссөний үр дүнд нэг эмчид ноогдох малын тоо 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнтэй холбогдуулан малын эрүүл мэнд, хүн амын хүнсний аюулгүй байдлыг сахин хамгаалдаг малын эмч, хувийн мал эмнэлгүүдийн тоо жил дараалан нэмэгдэж байна.

1.3. МАЛ АЖ АХУЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛЧДЫН МЭДЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ:

Мал аж ахуйн мэргэжилтнийг сургах, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд төрийн байгууллага болон хувийн ТББ, гадаадын төслүүд, эрдэм шинжилгээний хүрээлэн, ХААИС-тай хамтран мал аж ахуй, бэлчээр, хоршоо, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хурал, сургалт, зөвлөгөөн зохион байгуулж нийт 24507 мэргэжилтэн, малчдыг хамруулсан байна.

Хоёр. Малын үржлийн ажил үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

2.1. МАЛЫН УДМЫН САНГ ХАМГААЛАХ:

Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний анхан шатны нэгжийн үйл ажиллагааны стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах арга хэмжээний хүрээнд: “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, “Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн 5.3, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 1.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2010 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/215 тоот тушаалаар “Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа”-ны MNS5368-1:2011, MNS5368-2:2011, MNS5368-3:2011 стандартыг шинээр боловсруулж, батлуулав.

Стандартын дагуу 2013 онд түвшин тогтоох үзлэгээр нийт нэгжийн 88.0% нь ажлын байр, 93.0% нь шаардлага хангасан унаатай, 9.0% нь стандартын шаардлага бүрэн хангасан, 55.0% нь стандартын шаардлага хангаж байгаа, 36.0% нь дундаас доош түвшинд байгаа дүн үзүүлсэн бол 2014 оны байдлаар нийт нэгжийн 86.0 хувь нь стандартын шаардлага хангасан ажлын байр, 91.0 хувь нь унаагаар хангагдсан, нийт нэгжийн 5.0 хувь онцгой сайн, 50.0 хувь стандартын шаардлага хангасан, 42.0 хувь дунд үнэлгээтэй, 3.0 хангалтгүй үнэлгээг үзүүлсэн байна.

Цөм сүргийн малыг үржүүлж, чанар, стандартын шаардлага хангасан үр, хөврөл үр үйлдвэрлэх үүсгэл санаачилгыг дэмжих арга хэмжээний хүрээнд: Монгол Улсын засгийн газрын 2013 оны 420 дугаар тогтоолоор төрийн өмчийн хорооны харъяа Цөм сүргийн үржлийн төвүүдийг Малын удмын сангийн үндэсний төвийн харъяанд салбар аж ахуй болгон аж ахуйн тооцоон дээр ажиллуулахаар шийдвэрлэсэн. Төсөвт болон аж ахуйн байгууллага нэгдэн ажиллах нь санхүүгийн хувьд хүндрэлтэй байсныг засах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн сайдын “Цөм сүргийн үржлийн төв байгуулах тухай” 2015 оны А/52 дугаар тушаал гаргаж, цөм сүргийн үржлийн 12 төвийг байгуулж, үлгэрчилсэн дүрмийг баталж, аж ахуйн бие даасан хэлбэрээр, дотоод тооцоон дээр ажиллахаар шийдвэрлэсэн.

Төрийн өмчит Цөм сүргийн үржлийн 12 төвүүдэд малчид, мал аж ахуйн мэргэжилтэн, эрдэмтэн, аж ахуйн удирдлагуудын нөр их хөдөлмөр, хөрөнгө зарж, манай орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон “Төхөм тунгалагын хүрэн” үүлдэр, “Ханын хэцийн хүрэн” омгийн тэмээ, “Нутгийн шилмэл” адуу, махны чиглэлийн “Сэлэнгэ” үүлдэр болон “Дорнод талын мах”-ны хэвшлийн” үхэр, Нарийн ноост “Хангай”, нарийвтар ноост “Тал нутгийн цагаан”, махноосны чиглэлийн “Баяд”, “Сартуул”, “Дархад”, “Говь-Алтай”, “Байдраг”, махны чиглэлийн “Барга”, “Үзэмчин”, “Монгол” үүлдрийн хонь, ноолуурын чиглэлийн “Говь гурван сайхан” үүлдрийн болон “Эрчим”, “Баяндэлгэр”-ийн омгийн ямаа зэрэг үүлдэр, омог, хэвшлийн мал сүргийн удмын санг хамгаалах, иргэд, аж ахуйн нэгжийг үржлийн хээлтэгч, хээлтүүлэгчээр хангах чиглэлээр ажиллаж байна.

Төрийн өмчит 12 цөм сүргийн төвд хонины 9 үүлдэр, үхрийн 1 үүлдэр, адууны 1 үүлдэр, ямааны 1 үүлдрийн 2012 онд 13511, 2013 онд 12517, 2014 онд 13076, 2015 онд 14097 толгой малыг өсгөн үржүүлж, бүс нутгийн түвшинд үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчийг бойжуулж байна.

Цөм сүргийн малын тоо:

| № | Аймаг | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|---|------------|------|------|------|-------|
| 1 | Баянхонгор | 842 | 783 | 622 | 514 |
| 2 | Булган | 1605 | 1436 | 1237 | 1109 |
| 3 | Говь-Алтай | 1373 | 1542 | 1867 | 1772 |
| 4 | Дорнод | 486 | 390 | 456 | 516 |
| 5 | Дундговь | 456 | 484 | 531 | 535 |

| | | | | | |
|-----|-----------|-------|-------|-------|-------|
| 6 | Завхан | 2464 | 2488 | 2612 | 2718 |
| 7 | Өмнөговь | 236 | 246 | 309 | 309 |
| 8 | Сүхбаатар | 695 | 604 | 666 | 758 |
| 9 | Төв | 132 | 130 | 139 | 118 |
| 10 | Увс | 3432 | 2930 | 3082 | 4191 |
| 11 | Хөвсгөл | 1189 | 969 | 949 | 951 |
| 12 | Хэнтий | 601 | 515 | 606 | 606 |
| Дүн | | 13511 | 12517 | 13076 | 14097 |

*-Урьдчилсан байдлаар үндэсний төв

Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн

Цөм сүргийн малын тоо толгой өмнөх оноос урьдчилсан мэдээллээр 1021 толгойгоор өссөн дүнтэй байна.

Цөм сүргийн үржлийн төвийн үзлэг ангилалтад 20.6 сая төгрөгийг зарцуулж, 12491 толгой малыг хамруулж 7658 толгой буюу 61.3 хувь нь үүлдэр, омгийн шаардлага хангаснаас шилмэл болон I ангид 5786 толгой буюу 46.3 хувийг эзлэж байгаа нь тухайн үүлдэр, омгийн малын үүлдэрлэг байдал, чанарын үзүүлэлтийг хангаж, ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг бүрэн зохион байгуулав.

Монголд үржүүлж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийн түвшинг судлан тогтоож, зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржил-селекцийн ажил зохион байгуулах арга хэмжээний хүрээнд: Манай оронд үржүүлж буй 40 гаруй үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омгийн малын ашиг шимийн байдалд хянан магадлагаа хийж цаашид өсгөн үржүүлэх зөвлөмжийг 2011 онд гарган, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Мал сүргийн үүлдэрлэг байдал:

| Малын төрөл | Үүлдэр | Үүлдрийн хэсэг | Үржлийн хэсэг | Омог |
|-------------|-----------|----------------|---------------|-----------|
| Адуу | 1 | - | 1 | 3 |
| Тэмээ | 1 | - | 1 | 2 |
| Үхэр | 7 | 1 | - | - |
| Хонь | 11 | 3 | 3 | 3 |
| Ямаа | 3 | 1 | 1 | 5 |
| Бүгд | 23 | 5 | 6 | 13 |

Мэдээллийн эх сурвалж: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Тайлант 2015 онд “Мал, тэжээвэр амьтдын үржил селекцийн ажлын ололтыг хянан магадлах, баталгаажуулах бүртгэх, хяналт тавих журам”-ын дагуу тэмээний 3 үүлдэр, хонины 1 үүлдэр, 2 омог, ямааны 3 үүлдэрийг баталгаажуулсан.

Баталгаажуулсан үүлдэр, омог:

| Малын төрөл | Үүлдэр | Омог | Тайлбар |
|-------------|--------|------|--|
| Адуу | - | - | - |
| Тэмээ | 3 | - | “Төхөм тунгалагийн хүрэн”, “Галбын говийн улаан”, “Ханын хэцийн хүрэн” |
| Үхэр | - | - | - |
| Хонь | 1 | 2 | “Дархад” үүлдэр, “Буриад”, “Баянгол” омог |
| Ямаа | 3 | - | “Залаа жинст-Эдрэн”, “Завхан буурал”, “Баяндэлгэрийн улаан” |
| Бүгд | 7 | 2 | |

Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Арвин ашиг шимт хээлтүүлэгч малын үр, хөврөл үр, биотехнологийн дэвшилтэт аргыг хэрэглэж бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд: “Барга, Торгууд үүлдрийн хонь, Алтайн улаан үүлдрийн хэсгийн ямааны үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор стандартын шаардлага хангасан “Алтайн улаан ямаа”-ны 200 өсвөр хээлтүүлэгч, “Барга үүлдрийн хонь”-ны 200 өсвөр хээлтүүлэгч, “Торгууд үүлдрийн хонь”-ны 200 өсвөр хээлтүүлэгчийг бүс нутгийн мэргэжлийн байгууллагаар бэлтгэн, ГовьАлтай, Дорнод, аймгийн хонь, ямаан сүрэгт, “Үзэмчин үүлдрийн хонины өсвөр хээлтүүлэгч импортлох” худалдан авах арга хэмжээний хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-оос үзэмчин үүлдрийн 20 толгой хээлтүүлэгчийг

худалдан авч Сүхбаатар, Дорнод аймгийн аймгийн хонин сүрэгт сайжруулагчаар ашиглаж байна.

Сүү, махны чиглэлийн үхэр, нарийн нарийвтар ноост болон хурганы арьсны чиглэлийн хонь зэрэг төрөлжсөн үүлдрийн, бүтээмж өндөртэй мал үржүүлэх арга хэмжээний хүрээнд: Бүсийн төвүүд болон газар тариалангийн бүс нутгуудад эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор улсын төсвөөс хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлснээр эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн тоо 2010 оноос 1.7 дахинаар, 2005 оноос 7.8 дахинаар тус тус өссөн байна.

Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн тоо:

| № | Төрөл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|------------------|-------------|-------------|--------------|-------------|-------------|-------------|
| | ДҮН | 1284 | 1679 | 11737 | 1933 | 3178 | 2196 |
| 1 | Сүүний үхэр | 649 | 901 | 977 | 912 | 1432 | 1156 |
| 2 | Махны үхэр | 101 | 64 | 79 | 88 | 351 | 248 |
| 3 | Мах, ноосны хонь | 128 | 200 | 229 | 10259 | 236 | 397 |
| 4 | Гахай | 190 | 187 | 181 | 314 | 476 | 331 |
| 5 | Тахиа | 148 | 217 | 152 | 321 | 405 | 244 |
| 6 | Зөгий | 68 | 81 | 89 | 35 | 83 | 161 |
| 7 | Ямаа | - | - | - | 9 | 4 | 6 |
| 8 | Туулай | - | - | - | 18 | 30 | 50 |

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Хөтөлбөрийн эхний шатанд сүүний үхэр, махны үхэр, мах-ноосны хонь, гахай, тахиан аж ахуй эрхэлж байсан бол II үе шатанд шинээр зөгий, сүүний ямаа, туулайн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуй нэгж шинээр бий болсон байна.

Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжид өсгөн үржүүлж мал, амьтны тоо:

| № | Төрөл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|------------------|---------------|---------------|----------------|----------------|---------------|---------------|
| | ДҮН | 549187 | 763699 | 2217987 | 2183844 | 952736 | 882436 |
| 1 | Сүүний үхэр | 21412 | 27501 | 32876 | 37518 | 59799 | 61981 |
| 2 | Махны үхэр | 11307 | 11069 | 11247 | 5925 | 12705 | 20847 |
| 3 | Мах, ноосны хонь | 101681 | 161597 | 253810 | 1558446 | 43388 | 79226 |
| 4 | Гахай | 15064 | 16779 | 17775 | 31501 | 32094 | 29946 |
| 5 | Тахиа | 397468 | 451705 | 594936 | 544234 | 761973 | 761794 |
| 6 | Зөгий | 2255 | 2835 | 2707 | 4624 | 5876 | 6309 |
| 7 | Ямаа | - | - | - | 898 | 542 | 927 |
| 8 | Туулай | - | - | - | 698 | 521 | 632 |

Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй аж ахуй тоо нэмэгдснээр түүнд өсгөн үржүүлж буй малын тоо өссөн. 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 2196 иргэн, аж ахуй нэгжид 882.4 мянган толгой мал, амьтныг үржүүлж байна.

Засгийн газар, НҮБ-ын ХХААБ-тай хамтран 2008-2010 онд хэрэгжүүлсэн “Малын үржлийн ажлыг шинэчлэн сайжруулах” техник хамтын ажиллагааны төслийн хүрээнд Малын удмын сангийн үндэсний төвд Монгол улсад үржүүлж буй сүүний үхрийн удам зүй, гарваль, ашиг шимийн цэгцтэй бүртгэл мэдээллийн санд тулгуурлан сайжруулах үржлийн суурийг тавьснаар манай улсын эрчимжсэн сүүний үхрийн аж ахуй эрхлэх бүс нутгийн 380 саалийн аж ахуй эрхлэгчдийн 11093 үнээ, гунж бүртгэгдэж, сар бүр үржлийн болон ашиг шимийн бүртгэлийг тухайн орон нутагт байх үржлийн тоо бүртгэгч нараар хийлгэн цуглуулж, мэдээллийн санд баяжилт хийх ажлыг тасралтгүй гүйцэтгэж байна.


Бүртгэлийн дүнгээр бүртгэлд хамрагдсан 11.0 мянган толгой үнээний хоногийн дундаж саам 9.5 кг, тослогийн хэмжээ 3.66 хувь, уураг 3.16 хувь байна.

Эрчимжсэн сүүний үхрийн аж ахуй ашиг шимийн үзүүлэлт:

| Он | Тослог, % | Уураг, % | Тос+Уураг, кг | Санхүүжил, сая.төг |
|------|-----------|----------|---------------|--------------------|
| 2011 | 4.02 | 3.45 | 0.55 | 30.0 |
| 2012 | 3.97 | 3.27 | 0.54 | 30.0 |
| 2013 | 3.96 | 3.17 | 0.58 | 30.0 |
| 2014 | 3.77 | 3.11 | 0.61 | 30.0 |
| 2015 | 3.66 | 3.16 | 0.63 | 21.0 |

Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн үндэсний төв

Сүүний үхрийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхэлсэн 2008 онд нэг үнээний 305 хоногийн саамын хэмжээ 1799 кг байсан бол 2015 онд 3009 кг болж нэмэгдсэн байна.



Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн үндэсний төв

Сүүний чиглэлийн үнээний зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг нийслэл болон томоохон хотуудын орчимд байгуулж ажиллуулах арга хэмжээний хүрээнд: Нийслэлийн болон томоохон хотуудын ойролцоох эрчимжсэн аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжүүдийн захиалгаар 2010 оноос хойш зохиомол хээлтүүлгийн 501 техникч оролцож, нийт 97.2 мянган толгой малд зохиомол хээлтүүлгийг хийсэн байна.

Зохиомол хээлтүүлгийн үзүүлэлт:

| | | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | Дүн |
|---------------------------------------|-----|------|-------|-------|------|------|------|-------|
| Зохиомолоор хээлтүүлсэн мал | Бод | 2315 | 3352 | 4422 | 1919 | 2583 | 3479 | 23687 |
| | Бог | 7340 | 20563 | 13570 | 3647 | 5079 | 5093 | 73520 |
| Бүгд | | 9655 | 23915 | 17992 | 5566 | 7662 | 8572 | 97207 |
| Зохиомол хээлтүүлэгийн техникчийн тоо | | 40 | 88 | 33 | 59 | 111 | 50 | 501 |

Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн үндэсний төв

Малын удмын сангийн үндэсний төвд хадгалагдаж байгаа арвин ашиг шимт хээлтүүлэгч малын гүн хөлдөөсөн үрийг сүүний, махны чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу Малын удмын сангийн үндэсний төвтэй гэрээгээр ажилладаг мал үржүүлгийн техникчээр дамжуулан биотехнологийн дэвшилтэд технологи болох зохиомол хээлтүүлгийн аргаар удам зүйн дэвшлийг түргэн хугацаанд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр 2015 онд мал үржүүлгийн 31 техникчтэй гэрээ байгуулан, 919 литр шингэн азот, 3800 тун өндөр ашиг шимт бухны гүн хөлдөөсөн үрийг орон нутгийн нэгжүүдэд хүргэн мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгч ажиллуулсанаар 3479 үнээ, 5093 толгой хонь, ямаа нийт 8572 толгой малыг зохиомлоор хээлтүүлсэн байна.

Малын удмын сангийн үндэсний цогцолборыг байгуулах арга хэмжээний хүрээнд: Мал, амьтны удмын санг хамгаалах, цөм сүргийн малын гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаанд тулгуурлан нутгийн шилдэг омог, үүлдэр, гадаадын арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах болон биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар донор сүрэг бий болгож гүн хөлдөөсөн үр, хөврөл үр үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах, малд зохиомол хээлтүүлэг хийх, монгол малын генийн санг зохистой ашиглах, хадгалах, түүний ашигтай онцлог шинж чанар, удам зүйн дэвшлийг сурталчлах, түгээх ажил, үйлчилгээг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий “Малын удмын сангийн үндэсний цогцолбор”-ыг байгуулах зорилтын хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр багийн нутагт Буурал уулын энгэрт Хонгор сумын Засаг даргын 2011 оны 194 дүгээр захирамжаар цогцолборын барилга байгууламжид зориулан 22.3 га, малын тэжээл тариалах зориулалтаар 200 га, нийт 222.3 газар (0174879 дугаартай гэрчилгээ)-т байгуулах ажлыг эхлүүлсэн.

Цогцолбор байгуулахад улсын төсвөөс зарцуулсан зардал:

| № | Он | Гүйцэтгэл /сая. төг/ |
|-------------|------|----------------------|
| 1 | 2011 | - |
| 2 | 2012 | 750.0 |
| 3 | 2013 | 3460.2 |
| 4 | 2014 | 6464.3 |
| 5 | 2015 | 1000.0 |
| 6 | 2016 | 609.4 |
| Бүгд | | 12283.9 |

Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн үндэсний төв

Гүйцэтгэгч “НАБСАН” ХХК нь гэрээний дагуу нийт 14 барилга байгууламжийг хүлээлгэн өгөх бөгөөд цогцолборын ажлын явц 2015 оны жилийн эцсийн байдлаар дараах байдалтай хэрэгжиж байна.

Цогцолборын барилгын гүйцэтгэл:

| № | Барилга байгууламж | Гүйцэтгэлийн явц |
|----|---|--|
| 1 | Дулаан дамжуулах төв -2 | Тоног төхөөрөмж угсралтын ажил , ажлын зургын дагуу хийж угсарч дууссан. |
| 2 | Үйлдвэрлэлийн байр | А,Б,В блокуудын барилга угсралт дууссаж сантехник , цахилгааны угсралтын ажил, заслын ажлууд явагдаж байна. |
| 3 | 20 бухны зуны байр | Байрны гадна саравч, нарлагааны талбайн хуваалтыг барилга бүтээцийн зургийн дагуу бэлдцийг хийж угсарсан. |
| 4 | Адууны байр (10 азрага), (5 гүү, 5 унага) | Барилга угсралтын ажил дууссан дотор талын услагааны тосгуурын ажил хийгдэж байна. |
| 5 | 50 хуц, 30 ухнаны байр | Барилга угсралтын ажил дууссан. |
| 6 | Мал эмнэлгийн байр | Барилга угсралтын ажил дууссан. |
| 7 | 10 бухны өвлийн байр | Барилга угсралтын ажил дууссан. |
| 8 | Нийтийн бие засах газар | Барилга угсралтын ажил дууссан. |
| 9 | Саалийн үнээний байр | Барилга угсралтын ажил дууссан. |
| 10 | Дэд өртөөний - 2 | барилгын ажил дууссаж, тоног төхөөрөмж бүрэн бүтэн суурьлагдсан |
| 11 | Уурын зуухны барилга | 2 ширхэг уурын зуух нь барилгад багтахгүй байгаа учраас гүйцэтгэгч “Набсан” ХХК-ийн инженерүүд, зургийн автор “ББСМО” ХХК-тай зөвшилцөж, барилгын газрын кадастар дотор зөөж, уурын зуухны барилгын металл каркас, хашлаг хана болон дээврийн угсралтын ажил бүрэн дууссаж уурын зуухны технологийн системийн угсралтын ажлыг дуусах шатандаа байна. |
| 12 | Тэжээлийн үйлдвэрлэл | Суурь багана, дам нурууны металл каркасын угсралтын ажил дууссаж, хашлага, хана, дээврийн болон бусад ажил үлдсэн байна. |
| 13 | Цэвэрлэх байгууламжийн | Цэвэрлэх байгууламжийн угсралтын ажил дуусах шатандаа байна. |

2.2. ДОТООДОО ҮЙЛДВЭРЛЭХ, ИМПОРТООР АВАХ ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН:

Тоо нь цөөрч байгаа үүлдэр, омог болон гойд ашиг шимтэй малын удмын санг хамгаалах, зохистой ашиглах, үрийг нь хадгалах арга хэмжээний хүрээнд: Үр үйлдвэрлэлийн чиглэлээр 2012-2015 онуудад Малын удмын сангийн үндэсний төвийн үрийн санд 19 үүлдэр, омгийн 32252 үрийг стандарт арга зүйн дагуу авч хадгалсан байна.

Дотооддоо үйлдвэрлэсэн үр:

| Төрөл | Үүлдэр омгийн нэр | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | Дүн |
|-----------------|------------------------|-------------|-------------|-------------|-------------|-------------|--------------|
| Бух | Алатау | | 772 | 300 | 360 | | 1432 |
| | Симменталь | | 712 | 1197 | 480 | | 2389 |
| | Хар тарлан | | | 269 | | | 269 |
| | Сэлэнгэ | | | | 180 | | 180 |
| Дүн | 4 | | 1484 | 1766 | 1020 | 0 | 4270 |
| Хуц | Орхон | | | 3036 | 797 | | 3833 |
| | Хангай | | | 1767 | 937 | | 2704 |
| | Ерөө | | | 2268 | 520 | | 2788 |
| | Байдраг | | | 125 | | | 125 |
| | Сүмбэр | | 2704 | | | | 2704 |
| | Барга | 600 | 1237 | | 160 | | 1997 |
| | Үзэмчин | 600 | 1126 | 437 | 410 | 3135 | 5708 |
| | Халх | | 590 | 25 | | | 615 |
| | Тал нутгийн цагаан 95 | | | | 1385 | 1660 | 3045 |
| | Тал нутгийн цагаан 109 | | | | 899 | | 899 |
| | Сартуул | | | | | 1666 | 1666 |
| | Эделбайев | | | | | 1545 | 1545 |
| Дүн | 11 | 1200 | 5657 | 7658 | 5108 | 8006 | 27629 |
| Ухна | Буурал | | | 25 | | | 25 |
| | Өнжүүл | | 228 | 35 | | | 263 |
| | Альпин | | | 43 | | | 43 |
| | Залаа жинст | | | 22 | | | 22 |
| Дүн | 4 | | 228 | 125 | 0 | 0 | 353 |
| Нийт дүн | 19 | 1200 | 7369 | 9549 | 6128 | 8006 | 32252 |

Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн үндэсний төв

Үр үйлдвэрлэлээр 2012 онд 7369, 2013 онд 9549, 2014 онд 6128, 2015 онд 8006 тун үрийг тус тус авч генийн санг баяжуулсан байна.

Малын удмын сангийн үндэсний төв нь 2010-2011 онд улсын төсвийн хөрөнгө болон НҮБ-ын ХХААБ-ын “Малын үржлийн ажлыг шинэчлэн сайжруулах” төсөл, Словак улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд махны үхрийн 4500, сүү-махны үхрийн 7298, сүүний үхрийн 6529, 2014 онд 6200, нийт 24527 тун үр, улсын төсийн хөрөнгөөр 2014 онд 10000, 2015 онд 9000 тун үрийг нийт 197.0 сая төгрөгт импортоор худалдан авч, малын удмын сангийн үндэсний төвөөр дамжуулан мал сүргийн чанар сайжруулахад ашиглаж байна.

Импортээр худалдан авсан үр:

| № | Үүлдэр | Төсвөөс | | Гадаадын төслөөр | |
|---|--------------|---------|------|------------------|------|
| | | 2014 | 2015 | 2010-2011 | 2014 |
| 1 | Симменталь | 3000 | 2700 | | 2500 |
| 2 | Швейцийн бор | 3000 | 3600 | | |
| 3 | Хар ангус | 1000 | 2700 | | 1200 |
| 4 | Хар тарлан | 3000 | 0 | | 2500 |
| | Дүн | 10000 | 9000 | 24527 | 6200 |

Мэдээллийн эх сурвалж: Малын удмын сангийн үндэсний төв

Үүний үр дүнд нийслэлийн ойролцоох эрчимжсэн аж ахуй эрхэлж буй иргэн аж ахуйн нэгжийн үхрийн сүүний гарц нэмэгдэх боломжийг бүрдүүлсэн.

2.3. ОНЫ ЭХНИЙ МАЛЫН ТОО:

УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал үндэсний хөтөлбөр”-ийн хоёрдугаар тэргүүлэх чиглэл, “Малын үржлийн ажлын 2021 он хүртэлх стратеги төлөвлөгөө”-ний дагуу монгол малын тэсвэрт чанарыг бататгах, цус ойртохоос урьдчилан сэргийлэх, биологийн боломжийг нь бүрэн ашиглах, байгалийн эрсдэл даах чадварыг бэхжүүлэх үржил селекцийн ажлыг зохион байгуулж байна.

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2015 оны жилийн эцэст малын тоо 55957.6 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 3975.0 мянган толгой буюу 7.6 хувиар өслөө. Тооллогын урьдчилсан дүнгээр адуу 298.8 мян.тол буюу 10 хувиар, үхэр 365.6 мян.тол буюу 10.7 хувиар, тэмээ 18.6 мян.тол буюу 5.3 хувиар, хонь 1718.6 мян.тол буюу 7.4 хувиар, ямаа 1573.3 мян.тол буюу 7.1 хувиар 5 төрөл дээр өссөн байна.

Малын тоо, мянган толгойгоор:

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|-------|---------|---------|---------|---------|---------|
| Бүгд | 36335.8 | 40920.9 | 45144.4 | 51982.7 | 55957.6 |
| Адуу | 2112.9 | 2330.4 | 2619.4 | 2995.8 | 3294.6 |
| Үхэр | 2339.7 | 2584.6 | 2909.5 | 3413.9 | 3779.5 |
| Тэмээ | 280.1 | 305.8 | 321.5 | 349.3 | 367.9 |
| Хонь | 15668.5 | 18141.4 | 20066.4 | 23214.8 | 24933.4 |
| Ямаа | 15934.6 | 17558.7 | 19227.6 | 22008.9 | 23582.2 |

*-Урьдчилсан байдлаар статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2014, Үндэсний

Нийт мал сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл сүүлийн 5 жилд нийт малд адуун сүргийн эзлэх хувь 0.1-0.2, үхэр 0.2-0.5, тэмээ 0.1, хонь 0.1-1.6, ямаа 0.2-1.8 хувийн өөрчлөлттэй гарсан нь сүргийн бүтцийн хувьд олон жилийн үзүүлэлттэй харьцуулан үзэхэд олон жилийн дунджын түвшинд байна.

Нийт малд 5 төрлийн малын эзлэх хувь:

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|-------|------|------|------|------|-------|
| Бүгд | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| Адуу | 5.8 | 5.7 | 5.8 | 5.8 | 5.9 |
| Үхэр | 6.4 | 6.3 | 6.4 | 6.6 | 6.8 |
| Тэмээ | 0.8 | 0.7 | 0.7 | 0.7 | 0.7 |
| Хонь | 43.1 | 44.3 | 44.4 | 44.7 | 44.6 |
| Ямаа | 43.9 | 42.9 | 42.6 | 42.3 | 42.1 |

*-Урьдчилсан байдлаар статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2014, Үндэсний

Мал сүрэгт цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл малын тоо мэдээллээс харахад цэвэр үүлдрийн үхэр, хонины тоо толгой өсөж, ямааны тоо толгой буурсан, Эрлийз үүлдрийн үхэр, хонь, ямааны тоо толгой өссөн, нутгийн шилмэл омгийн малын тоо 5 төрөл дээр өмнөх онуудаас нэмэгдсэн байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилмэл омгийн малын тоо:

| Төрөл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|----------------------------------|---------|---------|---------|---------|---------|--------|
| <i>Цэвэр үүлдрийн мал</i> | | | | | | |
| Бүгд | 1 194.3 | 1 241.0 | 1 261.9 | 1 195.8 | 1 404.4 | 1822.8 |
| Үхэр | 28.5 | 45.5 | 42.4 | 41.2 | 46.5 | 67.0 |
| Хонь | 981.1 | 938.3 | 933.0 | 949.1 | 1 234.9 | 1561.1 |
| Ямаа | 184.7 | 257.3 | 286.5 | 205.5 | 123.0 | 194.7 |
| <i>Эрлийз мал</i> | | | | | | |
| Бүгд | 409.8 | 469.1 | 565.2 | 225.7 | 385.8 | 595.0 |
| Үхэр | 63.2 | 86.0 | 68.1 | 75.6 | 99.5 | 118.3 |
| Хонь | 95.8 | 65.5 | 76.2 | 34.9 | 41.9 | 33.6 |
| Ямаа | 250.8 | 317.6 | 420.9 | 115.2 | 244.4 | 443.1 |
| <i>Нутгийн шилмэл омгийн мал</i> | | | | | | |
| Бүгд | 736.4 | 769.8 | 789.8 | 1 012.5 | 1 309.3 | 1582.0 |
| Тэмээ | 11.3 | 13.9 | 14.3 | 16.4 | 14.4 | 20.4 |
| Адуу | 25.1 | 23.2 | 24.1 | 79.1 | 57.2 | 87.7 |
| Үхэр | 2.1 | 5.3 | 5.9 | 5.5 | 8.5 | 6.1 |
| Хонь | 136.5 | 141.4 | 132.9 | 82.9 | 125.2 | 255.9 |
| Ямаа | 561.4 | 586.0 | 612.6 | 828.6 | 1 104.0 | 1211.9 |

*-Урьдчилсан байдлаар
статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2014, Үндэсний

2.4. НЭГ МАЛААС АВАХ АШИГ ШИМ:

“Малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх тухай” ажлын удирдамж, гэрээг боловсруулж, баталгаажуулан 11 аймгийн ХХАА-н газартай гэрээ байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган жил бүр хэрэгжилтийг зохион байгуулж байна. Тайлант 2015 онд үзлэг ангилалтанд нийт 305.7 мянган мал, үүнээс адуу 10.0 мянга, тэмээ 7.1 мянга, үхэр 11.5 мянга, хонь 130.2 мянга, ямаа 115.2 мянга, сарлаг 31.6 мянган толгойг хамруулж анги чанарыг тогтоов.

Ангилалтын дүнгээр нийт малын 16.8% буюу 51.4 мянган толгой мал шилмэл ангид, 25.2% буюу 77.1 мянган мал үржлийн I ангийн шаардлагыг хангасан дүнтэй байна. Улсын хэмжээнд нийт 376 өрх, 11 аж ахуй нэгжид үржлийн мал бойжуулах эрх олгон 68.2 мянган толгой хээлтэгчийг цөм сүрэгт бүртгэв. Малд үзлэг ангилалт хийх ажлыг үр дүнтэй гүйцэтгэх зорилгоор гэрээний үнийн дүнгийн 70 % болох 110.5 сая төгрөгийг ажил эхлэхэд олгож, үлдэгдэл 30%-ийг ажлын гэрээний үүргийн биелэлт, ажлын үр дүнг үндэслэн олгох ажлыг зохион байгуулав.

Аймгуудын ХХААГ-ын 2015 оны жилийн эцсийн байдлаар улсын дундаж нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлтийг нэгтгэн үзэхэд цэвэр, эрлийз малын 305 хоногийн саамны хэмжээ дунджаар 2014 онд 1958 кг, 2015 онд 2025 кг-д хүрч 67 кг-аар нэмэгдсэн.

Нэг малаас авах ашиг шимийн дундаж үзүүлэлт, аймгаар:

| № | Үзүүлэлт | 2014 | 2015 | Өөрчлөлт |
|---|---|------|------|----------|
| 1 | Цэвэр, эрлийз үнээний сүү /305 хоног/, кг | 1958 | 2025 | +67 |
| 2 | Ноолуур, гр | 349 | 350 | +1 |
| 3 | Нарийн нарийвтар ноос, кг | 2.6 | 2.7 | +0,1 |
| 4 | Бүдүүн бүдүүвтэр ноос, кг | 1.3 | 1.4 | +0,1 |

Мэдээллийн эх сурвалж: Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын тайлан


Ноолуурын гарьц дунджаар 2014 онд 349 гр, 2015 онд 350 гр-д хүрч 1 гр-аар, нарийн, нарийвтар ноосны гарьц 2014 онд 2.6 кг, 2015 онд 2.7 кг-д хүрч 0.1 гр-аар, бүдүүн, бүдүүвтэр ноосны гарьц 2014 онд 1.3 кг, 2015 онд 1.4 кг-д хүрч, 0.1 кг-аар тус тус нэмэгдсэн өөрчлөлт гарсан байна.

2.5. МАЛЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН САН, СҮЛЖЭЭГ БИЙ БОЛГОХ:


Мал сүргийг хувийн дугаартай болгон бүртгэлжүүлж мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл мэндийг тодорхойлох, бүртгэх, мэдээлэх, хянах тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд 2015 онд нийт мал сүргийн 60 хувь, 2021 онд 80 хувийг хамруулах, эхний ээлжинд үхэр сүрэг, цөм сүрэг, үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгч, Увс, Ховд, Баян-өлгий, Завхан, Говь-Алтай, Архангай, Баянхонгор, Хөвсгөл 8 аймгийн малыг эхний ээлжинд бүртгэлжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тайлант 2015 онд цөм сүргийн малыг ээмэгжүүлэх ажлын хүрээнд 14 аймгийн 31833 мал үүнээс үхэр 3463, хонь 23631, ямаа 4334, тэмээ 405-нд шаардлагатай ээмэгийг орон нутагт хүргэн, ээмэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд Архангай 2550, Баянхонгор 15820, Булган 590, Говь-Алтай 1800, Говьсүмбэр 1803, Дорноговь 1770, Дорнод 210, Завхан 2000, Өмнөговь 600, Сүхбаатар 110, Төв 2300, Хөвсгөл 2000, Хэнтий 200 нийт 31,833 мал үүнээс үхэр 3463, хонь 23631, ямаа 4334, тэмээ 405 -ийг шинээр ээмэгжүүлэн, бүртгэлжүүлсэн.

ЭЭМЭГЖҮҮЛСЭН МАЛ




БҮРТГЭЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ



Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Онлайн мэдээгээр Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 22 аймаг, нийслэлийн нийт 339 сум, дүүргийн 85.0 мянган малчин өрх, 9.1 мянган мал бүхий өрхийн нийт 2381.3 мянган малыг бүртгэн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад малын тоо 544.4-аар, малчин өрх, мал бүхий иргэний тоо 10.3 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

БҮРТГЭЛЖҮҮЛЭЛТ, аймгаар



Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Малын бүртгэлийн ажил, үйлчилгээ хариуцсан ажилтанг сургах, тэдгээрийг шаардлагатай программ хангамж, техник хэрэгсэл, багаж төхөөрөмжөөр хангах арга хэмжээний хүрээнд: Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх программ

хангамжийн тендерт шалгарсан “Интерактив” ХХК–аас программыг хүлээн авч 2012 онд улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулав.

Аймаг, нийслэлд бүртгэл хариуцсан мэргэжилтэний сургалтыг зохион байгуулж 22 аймаг нийслэлээс 760 гаруй мэргэжилтэн хамрагдсан. Сургалтын үеэр малын бүртгэл мэдээллийн программ хангамжийг аймгийн МҮА, сумын ЗДТГ-ын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтний компьютерт суулгаж гарын авлага, зөвлөмжөөр хангав.

Бүртгэлжүүлэлтийн программын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2013 оны 7 дугаар сараас 9 сар хүртэл хугацаанд 22 аймаг нийслэлийн 352 мэргэжилтэнд бүртгэлийн програм хангамжийн сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, гарын авлага, зөвлөмжийг орон нутгуудад хүргэн, нийт 247 компьютер вирустсан, 152 компьютерийн программ идвхигүй горимд шилжсэн байсныг идэвхтэй горимд шилжүүлж 62 компьютерийг форматалж, 10 компьютерийн гэмтэлийг засаж, нийт 335 компьютерийг идэвхтэй горимд шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулав.

Гурав. Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд:

3.1. МОНГОЛ УЛС ДАРААХЬ ӨВЧНӨӨР ТАЙВАН, ӨВЧИНГҮЙ СТАТУСЫГ ДЭЛХИЙН МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС АВАХ:

Монгол Улсыг үхрийн цээж өвчингүй, баруун бүсийн аймгуудыг малын гоц халдварт шүлхий өвчний вакцин хэрэглэдэггүй эрүүл бүс нутгийн статусыг дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулж, хяналтын болон хамгаалалтын бүс байгуулах арга хэмжээний хүрээнд: Монгол улсын Засгийн газраас Олон улсын худалдааны хорио цээрт гоц халдварт өвчнүүдээс мал сүргийг шат дараатай эрүүлжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрүүлж мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар ихэд анхаарч энэ чиглэлээр тодорхой үе шаттай арга хэмжээнүүдийг төлөвлөж Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг бодлогын баримт бичигт тусган хэрэгжилтийг шат дараатай авч хэрэгжүүлж байна. Аливаа халдварт өвчнөөс мал сүргийг бүрэн эрүүлжүүлэх, устгах, иж бүрэн хяналтад авах арга хэмжээ нь нарийн түвэгтэй биологийн процесс бөгөөд энэ нь тухайн өвчний үүсгэгчийн хэв шинж, онцлог, байгаль, цаг уур, гадаад орчин, малын тэжээллэг, арчилгаа маллагаанаас ихээхэн хамаарахаас гадна өнөөгийн даяаршиж буй дэлхийн улс орнуудын эдийн засаг, худалдаа, нийгэм соёлын харилцаанд гарсан шилжилт хөдөлгөөний идэвхжил, хил хязгаарын нээлттэй байдал нь халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд олон улс оронд гол бэрхшээл, сорилтыг үүсгэж байгаа юм.

Гэсэн хэдий ч Монгол Улс ДМАЭМБ-аас 2005 онд “Үхрийн мялзан өвчний халдваргүй орон”, 2006 онд “Үхрийн мялзан өвчнөөр тайван орон” статусыг тус тус авсан юм. “Үхрийн цээж өвчнөөр тайван орны статус авах баримт бичиг” боловсруулах ажлыг 2009 оноос Мал эмнэлгийн хүрээлэнтэй ажлын гэрээ байгуулан ажиллаж, ДМАЭМБ-аас ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу баримт бичигт дахин боловсруулалт, нэмэлт тодруулга хийж, нотлох баримтыг бүрдүүлэн 64 хуудас материалыг 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр ДМАЭМБ-д албан ёсны өргөдөл, хүсэлтийн хамт илгээж, тус байгууллагаас техникийн болон зөвлөх үйлчилгээг авч хамтран ажиллаж байна.

Тус байгууллагын төлөөлөгчид албан ёсны эрүүл бүс эсвэл улс гэсэн статусыг авах өвчний жагсаалтыг шинэчлэн баталлаа. Уг жагсаалтад үхрийн тархи сархиагтах эмгэг, шүлхий, үхрийн цээж, африкийн адууны мялзан гэсэн тэргүүлэх чиглэлийн 4 өвчин, түүнчлэн энэхүү статусыг цаашид гахайн сонгомол мялзан, бог малын мялзан төст өвчин гэсэн 2 өвчин дээр нэмж авахаар шийдвэрлэв.

Монгол улсын нутаг дэвсгэрийг Шүлхий өвчний вакцин таригдаагүй шүлхийгээр тайван эрүүл бүс, хяналтын болон шүлхийгээр тайван бүс, вакцин тарьдаг эрүүл бүс гэсэн 3 бүсэд хувааж, бүс бүрт хэрэгжүүлэх арга хэмжээний журмыг Засгийн газрын 2011 оны 247 дугаар тогтоолоор баталсан.

Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор мал эмнэлэг, хорио цээрийн 4 байгууламжийг Төв аймгийн Лүн, Архангай аймгийн Цахир, Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Булган аймгийн Хутаг-Өндөр сумдад 2012 онд байгуулж бүсүүд болон хяналтын цэгт мал эмнэлэг, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардлыг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж бүсүүдийн хооронд зорчих хүн, мал, амьтан, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд хорио цээрийн хяналт тавьж өвчний халдварыг таслан зогсоох, бусад нутаг дэвсгэрт тархаахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шүлхий өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги /2014-2018 он/ болон Гэнэтийн бэлэн байдлын төлөвлөгөөг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 25-ны А/112 тоот тушаалаар баталсан. Стратегийн зорилго нь баруун бүсэд вакцинжуулалт хийлгүйгээр шүлхийгүй бүс гэсэн статус авах, төвийн бүсийн шүлхийгүй гэсэн статусыг хадгалах, зүүн бүсэд гарч буй тархалтыг хянах явдал юм. Малыг гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдалтай олон улсын мэргэжлийн шинжээчид газар дээр нь ажиллаж нөхцөл байдалтай танилцсаны дараа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын Мал эмнэлгийн хэлтэс болон УМЭАЦТЛ-ийн удирдлагуудтай уулзаж үнэлгээний эхний үр дүнг танилцуулсан. Үнэлгээний багийн тайланд дурдсан зөвлөмжийн дагуу 2 удаагийн сургалт, 2 нэрийн сурталчилгааны хуудас, 5 удаагийн телевизын алсын зайн сургалт, 2 нэрийн самбар зэргийг шинээр байгуулан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын талаар 36 хуудас бүхий тайланг 12 дугаар сарын 27-ны өдөр ДМАЭМБ-ын Мал, амьтны шинжлэх ухааны хороонд тодруулга бүхий нэмэлт материал хүргүүлсэн.

Малын гоц халдварт, халдварт өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээний хүрээнд: Малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээнд 2010 оноос өмнө жилд дунджаар улсын болон орон нутгийн төсвөөс 6.0-7.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож байсан бол “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлагдаж, мал сүргийн эрүүл мэнд, цаашлаад малаас хүнд халдварладаг зооноз халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээнд төрөөс анхаарч зарцуулах зардал, санхүүжилтийг нэмэгдүүлснээр мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2011-2013 онд 21.3-24.5 тэрбум төгрөгийг зарцуулж бруцеллөз өвчинтэй тэмцэх үндэсний хэмжээний хөтөлбөрийг эхлүүлж, тэмцэх стратеги, жишиг ажиллагааны дэгүүдийг батлуулсан байна. 2013 оноос эхлэн улсын төсвийн хүндрэл, бусад шалтгаанаас хамаарч 2014 онд 17.9 тэрбум 2015 онд 18.1 тэрбум, 2016 онд 15.5 тэрбум төгрөгөөр батлагдсан байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 25 нэрийн нян, бактер, вирус, микоплазмаар үүсгэгддэг өвчнөөс сэргийлэх вакцин, эмчилгээний зориулалт бүхий 5 нэрийн хэт дархлаат ийлдэс, оношлуурын цомог болох антиген, хавсрага, гемолизин зэрэг бүтээгдэхүүн худалдан авах гэрээг Биокомбинат ТӨҮГ-тай гэрээ байгуулж, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн хэлтэс, 960 мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдэд технологит хугацаанд нь дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулсан.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, ийлдэс үйлдвэрлэхэд зарцуулсан зардал:


| № | Вакцин | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|-----------------|------------------------|-------------------------|------------------|------------------|------------------|
| Нийт дүн | | 5,236,267.0 | 4,821,517 | 6,021,392 | 5,691,864 |
| Вакцин | | Зардал /мян.төг/ | | | |
| Дүн | | 5,144,470.0 | 4,705,449 | 5,874,089 | 5,576,648 |
| 1 | Боом | 136,892.0 | 130915.2 | 202401.9 | 199816.8 |
| 2 | ДХХ | 433,223.3 | 538530.3 | 607843.3 | 638632.7 |
| 3 | ЦХХ | 739,383.4 | 711217.2 | 637053.9 | 576864.03 |
| 4 | Дуут | 74,789.5 | 74991.1 | 65385.8 | 65746.8 |
| 5 | Коли-ижбалнад | 54,646.9 | 53762.6 | 89957.1 | 97,536.8 |
| 6 | Галзуу | 34,207.5 | 38502.6 | 79144.5 | 79,835.8 |
| 7 | Үнээ, тугалын ижбалнад | 3,309.8 | 3174.9 | 16041.81 | 7,544.7 |
| 8 | Сохор догол | 379,827.3 | 395205.5 | 387888.8 | 392,771.1 |
| 9 | СД-ын өсгөвөр | 4,082.7 | 6620.9 | 5143.7 | 0.0 |
| 10 | Томуу | 50,320.9 | 58648.2 | 101406.5 | 137,268.3 |
| 11 | Шөвөг яр | 140,866.6 | 166110.8 | 188468.8 | 174,883.3 |

| | | | | | |
|---------------|---------------------------|-----------------------|------------------|------------------|------------------|
| 12 | ШЯ-ын өсгөвөр | 0.0 | 0 | 0 | 0.0 |
| 13 | Вирусын зулбах | 0.0 | 0 | 0 | 0.0 |
| 14 | Бруцеллэз штамм-19 | 275,562.4 | 189780.9 | 264264 | 127,050.0 |
| 15 | Бруцеллэз Рев-1 | 2,119,715.5 | 1755960.5 | 2252250 | 2,102,100.0 |
| 16 | сахуу | 149,398.7 | 263710.6 | 280352.7 | 293,715.8 |
| 17 | Диарей | 0.0 | 0 | 0 | 0.0 |
| 18 | Цэцэг | 155,924.1 | 20801.4 | 2554.2 | 51,084.0 |
| 19 | Гахайн ЦИ-ын вакцин | 13,480.7 | 15447.9 | 37522.45 | 35,690.3 |
| 20 | Ёлом | 10,086.7 | 8464.9 | 18653.5 | 20,116.7 |
| 21 | Мялзан | 2,596.1 | 3085.3 | 6242.67 | 7,229.2 |
| 22 | Шувууны тахал | 0.0 | 1.137 | 6369.6 | 7,197.6 |
| 23 | ДХХ-энтеробактериозын хам | 260,799.6 | 207122.8 | 527461.3 | 505,402.7 |
| 24 | Гаммаглобулин | 4,567.0 | | 2149.2 | 0.0 |
| 25 | Листериоз - АУФ | 79.3 | 0 | 79.3 | 0.0 |
| | Листериоз ХХ вакцин | 82,477.2 | 46111.1 | 64484.2 | 44,957.5 |
| 26 | Энтеробактериоз | 8,432.7 | 10380.5 | 17718.71 | 0.0 |
| 27 | Шувууны цусан халдвар | 9,800.3 | 6902.4 | 13251.45 | 11,204.0 |
| 28 | Шувуу томуу | 0.0 | 0 | 0 | 0.0 |
| Ийлдэс | | Зардал мян/төг | | | |
| Дун | | 91,797 | 116,068.1 | 147,302.4 | 115,216.2 |
| 1 | Боом | 7524.2 | 16266.4 | 16022.4 | 14029.7 |
| 2 | ДХХ | 25109 | 29540 | 39751.2 | 0 |
| 3 | ЦХХ | 31856.1 | 37669.5 | 46255.1 | 51060.1 |
| 4 | Коли-ижбалнад | 16089 | 16454.7 | 23856 | 24128.6 |
| 5 | Ижбалнад | 2262.3 | 5011.5 | 5436.4 | 7120.3 |
| 6 | Энтеробактериоз | 8956.4 | 11126 | 15981.3 | 18877.5 |

Мэдээллийн эх сурвалж: Бмокомбинат ТӨҮГ

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 2010-2015 онуудад жил бүр 30.5-53.2 сая малыг технологит хугацаанд нь хамруулсан байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал




Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Мал сүргийг дархлаажуулснаар 2015 оны жилийн эцсийн байдлаар 22 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн албадын мэдээгээр давхардсан тоогоор 860 суманд 1865 удаагийн гаралтаар 23 нэрийн халдварт өвчин бүртгэгдэж нийт 15797 мал өвчилсний 21 хувь буюу 3432 мал хорогдсон байна.

Халдварт өвчний гаралт, өвчлөлийг өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулан нь авч үзвэл 2014 оноос давхардсан тоогоор 131 сумаар, гаралт 926-аар, өвчлөл 16707 толгойгоор, хорогдол 1934 толгойгоор тус тус буурсан байна. Халдварт өвчний өвчлөлийн байдлыг авч үзвэл: Боом, дуут хавдар, шөвөг яр, энтеробактериоз, дотрын халдварт хордлого, цусан халдварт, листериоз, галзуу зэрэг өвчнөөр өвчилсэн малын тоо буурч, цахлай, брадзот өвчнөөр өвчилсэн малын тоо нэмэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛЫН ӨСӨЛТ, БУУРАЛТ
/2014 онтой харьцуулсан/



Эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 2010 онд 1.3, 2011 онд 3.8, 2012 онд 6.4, 2013 онд 3.3, 2014 онд 3.8, 2015 онд 8.0 төгрөгийг улсын төсөвт тусган, зарцуулсан байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал, зарцуулсан зардал:


| Он | Хамрагдсан малын тоо (сая.тол) | Вакцины үнэ (сая.төгрөг) | Үйлчилгээний хөлс (сая.төгрөг) | Оношлуурын зардал (сая.төгрөг) | Тандалтын зардал (сая.төгрөг) |
|------|--------------------------------|--------------------------|--------------------------------|--------------------------------|-------------------------------|
| 2011 | 11.9 | Тусламжийн вакцин | 2195.0 | 80.0 | 90.0 |
| 2012 | 21.3 | Тусламжийн вакцин | 3263.6 | 100.0 | 90.0 |
| 2013 | 24.8 | Тусламжийн вакцин | 2936.6 | 99.9 | 75.8 |
| 2014 | 14.8 | 5641.5 | 2314.1 | 206.9 | 101.0 |
| 2015 | 5.9 | 3166.0 | 942.9 | 166.3 | 70.0 |

Эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Шүлхий өвчний голомттой бүс нутгийн мэдрэмтгий мал сүргийг дархлаажуулах арга хэмжээнд 2010 онд давхардсан тоогоор 8.6, 2011 онд 11.9, 2012 онд 21.3 сая, 2013 онд 24.8, 2014 онд 14.8, 2015 онд 5.9 сая толгой малыг хамруулсан. Энэ хугацаанд Монгол улсад 2010 онд 24 удаагийн тохиолдол бүртгэгдсэн бол 2011-2012 онд шүлхийн дэгдэлт гараагүй байна.

“Малын эрүүл мэнд төсөл”-өөс баруун бүсийн мал эмнэлгийн лабораториудад багаж, хэрэгсэл худалдаж авах, засварлах, оношлуур, урвалж бодисоор хангах, боловсон хүчнийг сургах, дадлагажуулах, тандалт судалгааны арга зүй эзэмшүүлэхэд зориулж 114.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь тус аймгуудын лабораторийн оношлох чадавхид ахиц гарч шүлхийн оношилгоо, тандалтыг бие даан зохион байгуулах чадавхи бүрэлдсэн байна.

Баруун бүсийн аймгуудыг шүлхий өвчнөөс эрүүл, халдваргүй болохыг нотлох зорилгоор 2010 онд 6384, 2011 онд 9517, 2012 онд 9289 малаас дээж авч шинжилсэнээс 2010 онд 22, 2011-2012 онд тус бүр 11 дээж эерэг гарсан байна.



Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Шинжилсэн дээжийн тоо:

| | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|--------|-------|-------|-------|------|-------|-------|
| Бүс | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
| Баруун | 6384 | 9517 | 9289 | 2696 | 11425 | 8959 |
| Төвийн | 7248 | 9300 | 7170 | 269 | 1124 | 6000 |
| Зүүн | 3572 | 300 | 930 | 930 | 900 | 6580 |
| Бүгд | 17204 | 19117 | 17389 | 3895 | 13449 | 21539 |

Мэдээллийн эх сурвалж: Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори

Баруун бүсийн мал сүрэгт шүлхий өвчнөөр тайван, халдваргүй эсэхийг баталгаажуулах ийлдэс судлалын тандалт шинжилгээг 2015 онд баруун 7 аймгийн нийт 60 сумын 125 багийн 523 суурийн 8959 (үхэр-6954, хонь-1980, ямаа-15) шүлхийд мэдрэмтгий малын ийлдсийн дээж шинжлэн, УМЭАЦТЛ-т баталгаажуулсан шинжилгээний үр дүнд Ховд, Баян-Өлгий аймгийн 88 (83-үхэр, 5-хонь) дээжинд бүтцийн бус уургийн эсрэг бием илрэв.

Хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх арга хэмжээг жил бүр улсын төсөвт вакцины зардал, үйлчилгээний хөлсийг тусган вакцинжуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Хонины цэцэг өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал, үйлчилгээний хөлс: /2015 он/

| № | Аймгийн тоо | Сумын тоо | Хамрагдсан малын тоо /мян.тол/ | Хөлсний хэмжээ /сая.төг/ |
|---|-------------|-----------|--------------------------------|--------------------------|
| 1 | Сүхбаатар | 12 | 434.6 | 65.2 |
| 2 | Дорнод | 12 | 443.9 | 66.6 |
| 3 | Дорноговь | 7 | 50.0 | 7.5 |
| 4 | Хэнтий | 9 | 199.4 | 29.9 |
| | Дүн | 40 | 1128.7 | 169.2 |

Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

3.2. МАЛ СҮРГИЙГ АРХАГ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС ЭРҮҮЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Хөтөлбөрийн хүрээнд 2010 онд Завхан аймаг, 2011 онд баруун, төвийн бүсийн 8 аймаг, 2012 онд төвийн бүсийн 9 аймаг, 2013 онд зүүн бүсийн 3 аймаг, Завхан аймгийн бруцеллэз өвчнөөр өвчлөмтгий нийт мал сүргийг вакцинжуулалтанд тус тус хамруулсан. Улсын төсвийн санхүүжилт, вакцины үйлдвэрлэлийн хүрэлцээ хангамжаас хамааран 2014 оноос эхлэн зөвхөн богийн төл, охин тугалыг вакцинжуулалтад хамруулах ажлыг Өмнөговь аймгаас бусад бүх аймагт жил бүр зохион байгуулж байна.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2012 онд 8.7, 2013 онд 6.8, 2014 онд 7.5, 2015 онд 6.9 тэрбум төгрөгийг вакцины зардал болон тарилгын үйлчилгээний хөлсөнд олгосон байна.

Бруцеллэзын вакцинжуулалтанд зарцуулсан зардал:

| № | Вакцин | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|-------------|-------------------------------------|--------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| 1 | Бруцеллэз штамм-19 /сая.төг/ | 70.5 | 149.9 | 275.5 | 189.7 | 264.2 | 127.1 |
| 2 | Бруцеллэз Рев-1 /сая.төг/ | 518.3 | 1181.9 | 2119.7 | 1756.0 | 2252.3 | 2102.1 |
| 3 | Олгосон үйлчилгээний хөлс /сая.төг/ | | | 6317.3 | 4928.9 | 4986.8 | 4676.6 |
| Бүгд | | 588.8 | 1331.8 | 8712.5 | 6874.6 | 7503.3 | 6905.8 |

Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Вакцинжуулалтын арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтран зохион байгуулснаар 2011-2015 онд жил бүр 13.6-23.5 сая толгой малыг технологит хугацаанд хамруулсан байна.

Бруцеллэзын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал /бүсээр, мян.тол/:

| Бүс | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|-------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| Баруун | 7575.6 | 3370.5 | 4998.5 | 4149.4 | 4012.0 |
| Хангайн | 5692.7 | 11183.7 | 4873.4 | 5704.3 | 5020.0 |
| Төвийн | 388.0 | 8638.2 | 2671.9 | 3289.4 | 2962.0 |
| Зүүн | 0.0 | 0.0 | 6739.1 | 2342.0 | 2113.0 |
| Улаанбаатар | 0.0 | 335.0 | 97.2 | 125.2 | 121.0 |
| Дүн | 13656.3 | 23527.4 | 19380.1 | 15610.3 | 14228.0 |

Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Малын бруцеллэз өвчинтэй тэмцэх стратегийг ХХАА-н Сайдын 2015 оны А/154 дугаар тушаалаар батлуулан мөрдөж, хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга зүй, стандарт ажиллагааны заавар зэргийг шинэчлэн боловсруулж, дунд болон эцсийн үр дүнгийн үнэлгээ хийх, вакцинжуулалтын үр дүнд серомониторинг хийх, өвчлөлийн байдалд тандалт хийх зэрэг ажлуудыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэрэгжүүлж эхлээд байна.

Архаг халдварт бруцеллэз, адууны ям, халдварт цус багадалт, үхрийн сүрьеэ, лейкоз өвчний тандалт шинжилгээг жил бүр УМЭАЦТЛ, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудтай хамтран зохион байгуулав.

БРУЦЕЛЛЭЗЫН ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭ. /улсын хэмжээнд 2015 он/



Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Архаг халдварт өвчнүүдийн тандалт шинжилгээнд 2011 онд нийт 325.6, 2012 онд 527.4, 2013 онд 543.5, 2014 онд 484.0, 2015 онд 373.5 мянган толгой малыг хамруулсан байна.

Бруцеллэз өвчний халдварлалт 2012 оноос хойш жил дараалан буурч /2.5-0.03%/ байгаа бол адууны халдварт цус багадалт өвчний халдварлалт Улаанбаатар, Төв, Дархан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Орхон аймгуудад 0.08-0.34 хувийн халдварлалттай байна. Лейкоз өвчний хувьд эрчимжсэн мал аж ахуй хөгжсөн төвийн бүсэд нэг үрхийн фермийн аж ахуйд /Орхон аймаг/ 2013, 2014 онуудад өвчлөл илэрч байсан бол 2015 онд хийсэн тандалт, шинжилгээгээр өвчний халдвар илрээгүй байна.

Шинжилгээнд хамрагдсан мал, халдварлалтын хувь:


| Өвчний нэр | 2011 | | 2012 | | 2013 | | 2014 | | 2015 | |
|------------|-------------------------------|-----------------|-------------------------------|-----------------|-------------------------------|-----------------|-------------------------------|-----------------|-------------------------------|-----------------|
| | Шинжилсэн малын тоо /мян.тол/ | Халдварлалтын % | Шинжилсэн малын тоо /мян.тол/ | Халдварлалтын % | Шинжилсэн малын тоо /мян.тол/ | Халдварлалтын % | Шинжилсэн малын тоо /мян.тол/ | Халдварлалтын % | Шинжилсэн малын тоо /мян.тол/ | Халдварлалтын % |
| Бруцеллэз | 168.0 | 0.88 | 348.6 | 2.5 | 327.4 | 0.69 | 300.4 | 0.29 | 303.5 | 0.03 |
| Сүрьеэ | 36.8 | 0.06 | 56.7 | - | 77.0 | - | 75.4 | - | 28.2 | - |
| Ям | 43.9 | 0.19 | 84.2 | - | 82.9 | - | 74.0 | - | 38.2 | - |
| Лейкоз | 31.2 | 0.03 | - | - | 24.7 | 1.02 | 26.6 | 0.09 | - | - |
| АХЦБ | 45.7 | 0.08 | 37.9 | 0.2 | 31.5 | - | 7.6 | 0.34 | 3.6 | 0.1 |

Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Бруцеллэзын шинжилгээнд 2015 онд 291.7 мянган толгой малыг хамруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 303.5 мянган малыг хамруулсан ба шинжилгээний дүнгээр уг өвчний халдварлалт 0-5.4 хувьтай, үүнээс Ховд, Архангай, Говьсүмбэр аймгууд өндөр халдварлалттай гарсан байна. Сүрьеэ өвчний тандалт шинжилгээнд 26.6 мянган мал хамруулахаас 28.2 мянга, Адууны халдварт цус багасах өвчний шинжилгээнд 3.6 мянган мал хамруулахаас 3.6 мянга, Ям өвчний шинжилгээнд 35.3 мянган мал хамруулахаас 38.2 мянган мал тус тус хамруулан шинжлэхэд өвчлөл илрээгүй байна.

3.3. ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ДЭГДЭЛТ ГАРААГҮЙ БАЙХ:

Шүлхий болон хонь, ямааны цэцэг өвчний голомттой бүс нутаг дахь урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах замаар тархалтыг зогсоож, хамрах хүрээг багасгах арга хэмжээний хүрээнд: Малын гоц халдварт шүлхий өвчин 2000, 2001, 2002, 2004, 2005, 2006, 2010, 2014, 2015 онуудад тус тус оношлогдож, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

Шүлхий өвчин 2015 онд Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд аймгийн нэр бүхий 5 суманд 9 удаагийн голомтоор гарч 1024 мал өвчилж, 90 толгой малыг зааврын дагуу устгасан.

Манай оронд хонь ямааны цэцэг өвчин 1967, 1977 онуудад бүртгэгдэж, түүнээс хойш тайван байж байгаад 2006 оны 11 сард Сүхбаатар аймгийн Асгат, Баруун урт сумдад анх оношлогдож 2006-2007 онд нийт 7 сумын 14 голомтонд 978 хонь өвчилсөн байна. Ямааны цэцэг өвчин 2008 онд Дорнод аймгийн Хэрлэн, Баянт үмэн сумдад оношлогдож, нийт 423 ямаа өвчилсөн бүртгэгдсэн. Хонины цэцэг өвчин 2013 оны 1 дүгээр сард Дорнод аймгийн Хатанбулаг суманд оношлогдож тэмцэх зааврын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Хонины цэцэг өвчин 2015 онд Дорнод аймгийн Баянтүмэн суманд анх оношлогдож улмаар хил залгаа Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгийн 22 сумын нутаг дэвсгэрт халдварлаж нийтдээ 54 удаагийн голомтоор 1431 толгой мал, амьтан өвчилж 78 толгой малыг зааврын дагуу устгасан.

Аймгийн мал эмнэлэг, үржлийн албадын шуурхай дуудлагын болон ариутгал, халдваргүйтгэлийн автомашин, тоног, төхөөрөмжийн хангамжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд: Гоц халдварт, халдварт өвчний үеийн шуурхай бэлэн байдлыг аймгуудад хангах ажлын хүрээнд ОХУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 22 ширхэг тусгай зориулалтын ДУК автомашиныг аймгуудад 2012 онд олгов. ДУК машин нь мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдварт өвчний голомтонд дуудлагаар цаг агаарын ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвартай, халдваргүйтгэлийн уусмалыг бэлтгэх, 0+85 хэм хүртэл халаах, 8 метр хүртэлх өндөрт 2,5 МПа (кг/см²) хүртэлх даралтаар шүрших, нэг минутанд 8 литрээс доошгүй шингэнийг мананцар маягаар шүрших хүчин чадалтай.

Шинээр гарч байгаа болон дахин сэргэж байгаа, хил дамжин халдварладаг гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг аймаг, сумын түвшинд боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд: Мал эмнэлгийн салбарт МЭҮН-ийн стандарт, мал эмнэлгийн зориулалттай эм, вакцин үйлдвэрлэл, лабораторийн оношлогоо, шинжилгээний арга зүйтэй холбоотой нийт 252 стандарт, малын халдварт, паразиттах өвчинтэй тэмцэх, сэргийлэх 66 заавар 2011-2015 онд батлагдан гарч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Өнгөрсөн 2014 онд “Малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх дунд хугацааны (2014-2018) стратегийг шинээр боловсруулан 2012 онд батлагдсан бэлэн байдлын үндэсний төлөвлөгөө, зааварт өөрчлөлт оруулан батлуулж мөрдөгдөж эхэлсэн.

Малын эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээний салшгүй нэг хэсэг нь лабораторийн оношлогоо, шинжилгээний ажил байдаг. Монгол Улсын Засгийн газар тодорхой хөрөнгө гаргаж, хандивлагчдийн зүгээс төсөл хэрэгжүүлснээр мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, шүлхий, хонь, ямааны цэцэг, томуу зэрэг гоц халдварт өвчнийг олон улсын шинжилгээний стандарт арга зүйн дагуу 24-72 цагт багтаан оношлон, баталгаажуулах чадавх УМЭАЦТЛ болон аймгуудын түвшинд бүрдсэн. Мөн хүнсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндийг хангах ажлын хүрээнд “Мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журам”-ыг шинэчлэн боловсруулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

3.4. СУМ, ДҮҮРЭГТ МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЧАДАВХИТАЙ БОЛОХ:

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд 21 аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд аймгийн мал эмнэлгийн хэлтэс, сумдын хувийн мал эмнэлгийн нэгжээр дамжуулан жил бүр мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үзлэг, шалгалт, магадлан шинжилгээг гүйцэтгэдэг ба 2015 онд нийт 1743.4 мян.толгой малыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулсан бол мах, махан бүтээгдэхүүн 14341.4 мян.тонн, сүү сүүн бүтээгдэхүүн 5441.2 мян.литр, ноос ноолуур 19452.5 тонн, малын тэжээл 19567.1 тонн, арьс шир 5672.1 мянган ширхэгийг тус тус зохих стандарт аргачлалын дагуу шинжлэн мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээг олгосон байна. Түүнчлэн аймгийн мал эмнэлгийн албад, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран 56477 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн цайны газар, ресторан, хүнсний зах, дэлгүүр, худалдааны төв, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цех, тээврийн хэрэгсэл, гахай, шувууны аж ахуй, түүхий эдийн агуулах, зоорь, худаг уст цэг, малын хашаа, хороо зэрэгт мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шалгалтыг 266633 удаа хийж, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах асуудалд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн байна.

“Мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээ, мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний дүнгийн хуудас хэрэглэх журам”-ын төсөл нь “Малын эрүүл мэндийн гэрчилгээ”-ний загвар 8, “Мал эмнэлэг ариун цэврийн гэрчилгээ”-ний загвар 13, “Лабораторийн шинжилгээний дүнгийн хуудас”-ны загвар 3-аар тус тус боловсруулсан. Журам гарснаар хөдөө орон нутгийн МЭҮН-үүд нийт 21 аймаг, нийслэлийн МЭАЦЛ, хүнсний худалдааны төвийн лабораториуд гурван төрлийн шинжилгээний дүнгийн хуудсыг хэрэглэх болохоор тусгасан.

3.5. МАЛЫН ӨВЧНИЙ ОНОШЛОГООНЫ ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛГОХ:

Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнийг газар дээр нь шуурхай үнэн зөв оношлох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор орчин үеийн оношлогооны багаж хэрэгслээр тоноглогдсон 592.8 сая төгрөгийн үнэ бүхий 5 лабораторийг Архангай, Ховд, Дундговь, Хэнтий аймгуудын мал эмнэлгийн алба, УМЭАЦТЛ-т 2012 онд тус тус олгосон.

Мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээний нүүдлийн лаборатори нийлүүлэх тендерийн хүрээнд нийт 200.0 сая төгрөгний үнэ бүхи хөдөлгөөнт лаборатори нэг ширхэгийг дагалдах хэрэгсэл тоног төхөөрөмжийн иж бүрдэл, урвалж бодисуудыг УМЭАЦТЛ-т 2012 онд нийлүүлсэн.

3.6. МАЛЫН ЭМ, БИОБЭЛДМЭЛ /ВАКЦИН, ОНОШЛУУР/-ИЙГ ДОТООДОО ҮЙЛДВЭРЛЭХ:

Эм бэлдмэлийн хяналтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн шинжилгээний болон халдвар хамгаалал, биоаюулгүй байдлын чадавхийг сайжруулах зорилгоор 2014 онд багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээгээр 8 нэрийн 10 ширхэг 85.9 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж худалдан авч МЭЭСБУЛ-ийн сорилт, шинжилгээнд нэвтрүүлснээр тус лаборатори нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Эм бэлдмэл, вакцин хадгалах зориулалт бүхий 100.0 мкв хэмжээтэй хөргүүрийн өрөөг УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ-т угсарч байрлуулсан. МЭЭСБУЛ нь өөрийн орлогоор 100 хувь санхүүждэг санхүүгийн хараат байгууллага байсныг улсын төсвөөс зарим хэсгийг санхүүждэг болгосон ба 2010 онд 60.0 сая, 2011 онд 100.0 сая, 2012 онд 110.0 сая, 2013 онд 140.0 сая, 2014 онд 180.0 сая, 2015 онд 140 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт тусган хэрэгжүүлсэн байна.

МЭЭСБУЛ-иор 2015 онд мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй 50 аж ахуйн нэгжээс вакцин, ариутгал халдваргүйтгэлийн бодис, паразиттах өвчнөөс сэргийлэх туулгалт, угаалгын бэлдмэл, эмийн түүхий эд, антибиотик, боловсруулалт, өргөн хэрэглээний эм бэлдмэлийн 425 дээжинд, мөн Биокомбинат ТӨААТҮГ-аас улсын захиалгат тендерийн дагуу үйлдвэрлэсэн 250 гаруй цуврал бүтээгдэхүүнд сорилт, шалгалт, баталгаажуулалтын дүгнэлтийг гаргуулсан байна.

Хуурамч эмийг зах зээлд борлуулах ажлыг таслан зогсооход чиглэсэн хяналтыг сайжруулах зорилгоор мал эмнэлгийн практикт хэрэглэгдэж буй эмийн жагсаалтанд 2015 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 93 аж ахуйн нэгжийн 687 ширхэг эм бүртгэлтэй байгаагаас дотоодын 9 эмийн үйлдвэрийн 59 нэр төрлийн эм био бэлдмэл бүртгэгдсэн байна. МЭХ-ийн ШУТТ-ийн үр дүнд 16 нэр төрлийн шинэ эм бэлдмэл гаргаж авчээ.

Энэ ажлын хүрээнд МЭҮГ-аас Малын эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторитой хамтран малын эм ханган нийлүүлэх аж ахуйн нэгжүүд болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй эмийн сангуудад хамтарсан шалгалтыг удаа дараа зохион байгуулж мал эмнэлгийн практикт хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн гарал үүсэл, чанар аюулгүй байдалд дүн шинжилгээ хийв. Уг шалгалтаар Болгар улсын "BIOVET" малын эмийн үйлдвэрт үйлдвэрлэгдсэн МЭЭСБУЛ-иор сорилт баталгаажуулалтад хамрагдаагүй дараах нэрийн эм илрүүлсэн байна.

| Д/д | Эмийн нэр | Цувралын дугаар | Хүчинтэй хугацаа |
|-----|---------------------|-----------------|------------------|
| | Фармазин 50 | 140813218 | 08/2017 |
| | Фармазин 200 | 140713107 | 07/2017 |
| | Окситетрациклин 10% | 140911201 | 09/2016 |
| | Биоселет Е | 140810503 | 08/2016 |
| | Пандекс 1% | 140812605 | 08/2017 |

Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг, үржлийн газар

"Гүнтэрэм" ХХК-ий импортлосон Interspectin L-354702-р цувралын эмийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг зарсан, ОХУ-аас импортлосон зарим нэрийн эм бэлдмэл тухайлбал зорька нэрийн тос, ЛТФ130 вакцин, окситоцин 5ЕД 02-р цуврал, камфарное масло 30мл 10115-р цуврал, Солонгос хаягтай тос, Fenylbutazone 20% 03451-р цуврал, Dexamethazone G20511-16 цувралын эм, Про СМС морины нэмэлт тэжээл зэрэг зах зээлд зарагдаж буй бүтээгдэхүүнүүдийн импортлогч нь тодорхой бус, "Холч шарга" компанийн суперамино, аминолаите бэлдмэл нь МЭЭСБУЛ-иос сорилт, баталгаажуулалтын дүгнэлт аваагүй байж эмийн сангуудаар худалдаанд тараагдсан, "Эрхэт чандмань" ХХК-ий импортлосон Гаммавит 0815-р цуврал, "Дэлгэр Агьт" компанийн дэлэнгийн тос, дэлүүн тос зэрэг нь сорилт, баталгаажуулалтанд огт хамрагдаагүй зэрэг зөрчлүүдийг өнгөрсөн хугацаанд илрүүлж таслан зогсоосон байна.

Биокомбинат төрийн өмчит үйлдвэрийн газар нь Малын халдварт боом, дотрын халдварт хордлого, цусан халдварт, галзуу, дуут хавдар, колибактериоз, иж балнад, сохор догол, шөвөг яр, сахуу, гахайн мялзан, адуу, тэмээний томуу, хонины цэцэг, гахайн мялзан, ёлом, цусан халдварт-иж балнад, шувууны тахал, цусан халдварт зэрэг 25 нэрийн нян болон вирус, микоплазмаар үүсдэг өвчнөөс сэргийлэх вакцин, эмчилгээний зориулалт бүхий 5 нэрийн хэт дархлаат ийлдэс, оношлуурын цомог болох антиген, өвчтэй, эрүүл ийлдэс, хавсрага, гемолизин зэрэг 28 нэрийн 32 төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж орон нутагт ханган нийлүүлж байна.

"Вакцин хадгалах хүйтэн хэлхээг аймаг, нийслэлийн түвшинд бий болгох зорилгоор 18 аймаг, 2 лабораторит 45.0-55.0 м2 хэмжээтэй хүйтэн өрөө, вакцин тээвэрлэх 2 автомашин,

хөлдөөгч 23 ширхэг төхөөрөмжийг нийт 675.5 сая төгрөгт худалдан авч аймаг, нийслэлийн түвшинд хүйтэн өрөөний нэгдсэн сүлжээ бий болгов.

Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоо, сүлжээг бий болгох, тэдгээрийг дэмжих арга хэмжээний хүрээнд: Малын эмийн талаарх бодлого нь Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиуд Мал эмнэлгийн эмийн болон үйл ажиллагааны чиглэлээр мөрдөгдөж байгаа 260 гаруй стандарт /фармакопей/, ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлагдсан Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам, малын эм бүртгэлийн дүрэм, мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз зэрэг эрх зүйн актын хүрээнд Малын эмийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Малын эмийн чиглэлээр мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуйн нэгж, мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй 90 аж ахуйн нэгж, Улаанбаатар хотод 20 малын эмийн сан, аймгуудад Малын эмийн ханган нийлүүлэх сүлжээний 22 аж ахуйн нэгж, хөдөө орон нутагт хувийн мал эмнэлэг үйлчилгээний 900 гаруй нэгжийн эмийн сангаар дамжуулан мал бүхий иргэдийг улсын бүртгэлд бүртгэгдсэн 598 нэр төрлийн эм бэлдмэлээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн 2015 оны жилийн эцсийн байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл бүхий Монветмед, Холч шарга, Монгол Ви И Ти Нет, Эрхэтчандмань, УМЭАЦТЛ, Глобал бизнес линк, Шинэ-Уул вест, Монхорс, Тэнүүнхишиг, Эм Жи Эл Кей Ар, ЦЛМ, МЭХ, Еврофарм, Монфотрейд, Тэстэрх, МНХМЭД, Түмэншувуут, МХХБС, Агрохим, Эмийн үйлдвэр импекс, Иммунофилакси, Агротрейд, Ханбүрэгдэй, Зон дэм, Малчин монгол, Гүн тэрэм, Их хангай-Уул, Агриматк-Монгол, Чонос империал зэрэг 32 аж ахуйн нэгж Энэтхэг, БНСУ, Хойд Ирланд, ОХУ, БНХАУ, Австри, Вьетнам, Франц, Нидерланд, Япон, Герман, Унгар, ХБНГУ, Англи, Итали, Дани, Иордан, Их британ, Иордан, Болгар Испани, Чех, Австрали зэрэг 24 улсаас 2015 оны 12 дугаар сарын 15-ний байдлаар 222 лицензээр эм, эмнэлгийн хэрэгсэл импортлосон байна.

Аймгуудад байгуулагдсан Малын эм ханган нийлүүлэх сүлжээний аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай ХХААХҮЯ, Мал эмнэлэг, үржлийн газрын мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон, тусгай удирдамжийн дагуу 2 удаа танилцаж, холбогдох зааварчилгаа зөвлөмжийг өгч ажиллаа. Шинээр бүртгэгдсэн эмийн заавруудыг эмхэтгэн “Малын эмийн заавар” номонд нэмэлт оруулан Европын холбооны Мал аж ахуйн зах зээл төсөл, Мал эмнэлгийн газрын санхүүжилтээр 2 удаа хэвлүүлэн мэргэжилтнүүдэд гарын авлага болгон хүргүүлж, Монголын үндэсний Мал Эмнэлгийн Холбоотой хамтран эмийн санчийн сургалтыг 3 удаа зохион байгуулав. Мөн “Эмийн чанар, аюулгүй байдал”, “Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэл, боловсронгуй болгох үндэслэл шаардлага”, “Малын эмийн хангамж, нийлүүлэлт, аюулгүй байдал” сэдэвт сургалтуудыг орон нутгийн мэргэжилтнүүд, эм үйлдвэрлэгч болон импортлогч байгууллагын төлөөлөл 118 хүнийг хамруулав.

Дөрөв. Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

4.1. УЛС, АЙМАГ, СУМЫН ОТРЫН БҮС НУТГИЙН ТҮВШИНД ХАМГААЛАЛТАД АВАХ БЭЛЧЭЭРИЙН ХЭМЖЭЭ:

Засгийн газрын 2007 оны 187 дугаар тогтоолоор батлагдсан “аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны журам”, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А/158 дугаар тушаалаар батлагдсан “Отрын бүс нутгийн үйл ажиллагааны хөтөлбөр”, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2007 оны 99 дүгээр тушаалаар батлагдсан “Аймаг


дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дүрэм” зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Аймаг дундын болон сум дундын отрын бүс нутгийг шинээр бий болгох арга хэмжээний хүрээнд: Ховд аймгийн Дарви сумын нутагт “Баян-нуруун”-ы 105.2 мян/га талбайг улсын тусгай хэрэгцээний газарт авахаар Засгийн газрын 239 тоот тогтоолоор шийдвэрлэн аймаг дундын отрын бэлчээрийг шинээр өргөтгөн байгуулав. Аймаг дундын отрын 782.5 мян/га бэлчээрийг отрын бүсийн хэрэгцээний газарт авсан.


Улсын тусгай хэрэгцээний отрын бэлчээр:

| № | Аймаг | Батлагдсан огноо | Тогтоолын дугаар | Талбайн хэмжээ /мян.га/ |
|------------|-------------------------------------|------------------|------------------|-------------------------|
| 1 | Говь-Алтай аймгийн “Аргалант” | 2002 | 181 | 118.6 |
| 2 | Говь-Сүмбэр аймгийн “Малхын тал” | 2007 | 187 | 73.1 |
| 3 | Завхан аймгийн “Багахайрхан” | 2007 | 187 | 68.3 |
| 4 | Дорнод аймгийн “Чойбалсан” | 2009 | 100 | 124.4 |
| 5 | Хэнтий аймгийн “Хэрлэнбаян-Улаан” | 2009 | 165 | 192.8 |
| 6 | Төв, Булган, аймгийн “Чилэн” | 2010 | 64 | 34.0 |
| 7 | Өвөрхангай аймгийн “Хөх дэл”, | 2010 | 64 | 37.2 |
| 8 | Увс аймгийн “Ачит нуур” | 2012 | 158 | 28.9 |
| 9 | Ховд аймгийн Дарви сум “Баян нуруу” | 2014 | 239 | 105.2 |
| Дүн | | | | 782.5 |

Эх сурвалж: Аймаг дундын отрын бэлчээрийн захиргаа



Аймаг дундын отрын бүс нутгийг шинээр бий болгох, отрын бүсүүдийг хашиж хамгаалах, хаягжуулах, уст цэг барих, өвс, тэжээлийн агуулах, чулуун хороо, хамгаалалтын хашаа барих чиглэлээр 2010-2014 онд улсын төсвөөс нийт 2440.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.



Эх сурвалж: Аймаг дундын отрын бэлчээрийн захиргаа

4.2. МАЛЫН ТОО, ТӨРЛИЙГ БЭЛЧЭЭРИЙН ДААЦТАЙ УЯЛДУУЛАН МАЛЫН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААРЫГ /КВОТ/ ТОГТООХ:

Энэхүү арга хэмжээ хийгдээгүй.

4.3. АЙМАГ, СУМ БҮРТ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦИЙН САН, ТЭЖЭЭЛИЙН ЦЕХ БИЙ БОЛГОХ:

Сум дундын малын тэжээлийн нөөцийн цэг бий болгох арга хэмжээний хүрээнд: “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент төсөл”-ийн санхүүжилтээр 2015 онд Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Батцэнгэл, Булган аймгийн Дашинчилэн, Гурванбулаг сумдад өвсний саравч тэжээлийн агуулах барьж ашиглалтад оруулсанаар төсөл хэрэгжиж буй 15 сумдад саравч, агуулахтай болж байгаа бөгөөд үүнээс 9 нь төслийн санхүүжилтээр бусад нь улсын төсвийн болон бусад эх үүсвэрээр баригдсан. Төслийн сумдаас гадна аймаг орон нутгийн хүсэлт, үр ашигтай байдлыг харгалзан Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс, Архангай аймгийн Төвшрүүлэх суманд улсын нөөцийн өвс тэжээлийн агуулах савыг засаж сайжруулсан.

Төслийн санхүүжилтээр барьж, засварласан өвсний саравч, тэжээлийн агуулах:

| № | Он | Аймаг, сум | Хийж гүйцэтгэсэн ажил | Ашиглалтын байдал |
|----|------|-------------------------------------|-----------------------|---|
| 1 | 2012 | Хэнтий, Хэрлэнбаян-Улааны отрын бүс | Шинээр барьсан | - |
| 2 | 2013 | Говь-Алтай, Аргалантын отрын бүс | Шинээр барьсан | - |
| 3 | 2014 | Архангай, Батцэнгэл | Шинээр барьсан | 2015 онд 7 тонн өвс |
| 4 | | Булган, Дашинчилэн | Шинээр барьсан | 80 тонн өвс, 25 тонн тэжээл |
| 5 | | Хэнтий, Дэлгэрхаан | Шинээр барьсан | 50 тонн өвс |
| 6 | | Архангай, Төвшрүүлэх/улсын нөөцийн | Засвар | 2015-2016 оны өвөл 249 тонн өвс, 150 тонн тэжээл Архангай аймгийн сумдад хуваарилсан. |
| 7 | | Хөвсгөл, Цагаан-Уул | Хашаа барих | 2014 онд 85 тонн, 2015 онд 131,2 тонн өвсний нөөц |
| 8 | 2015 | Архангай Өгийнуур | Шинээр барьсан | 17,5 тонн өвс |
| 9 | | Архангай Өлзийт | Шинээр барьсан | 12 тонн өвс, 3 тонн тэжээл |
| 10 | | Булган, Гурванбулаг | Шинээр барьсан | 25 тонн өвс |
| 11 | | Хөвсгөл, Бүрэнтогтох | Шинээр барьсан | 104 тонн өвс |

Мэдээллийн эх сурвалж: Зах зээл ба бэлчээрийн менежмент төсөл

Шинээр баригдсан тэжээлийн агуулахын багтаамжийн хувьд 30 тонны, өвсний саравч нь 25 тонн буюу 1250 ширхэг боодол өвс хадгалах багтаамжтай.

Тэжээлийн нэг болон олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуйн нэгжийг бүсүүдэд байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих ажлыг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих арга хэмжээний хүрээнд: “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөөгийн амьжиргаа төсөл”-ийн дэмжлэгээр 2015 онд Баянхонгор аймгийн Бууцагаан, Хүрээмарал, Заг сумдын 906 малчин өрхийг нэгтгэсэн 65 малчны бүлэг нийт 656.0 тн хадлан, 630.1 тн хужир, 45.8 тн дарш бэлтгэсэн.

Тэжээл үйлдвэрлэл:

| Он | Малчны бүлэг | Гишүүн өрх | Бэлтгэсэн /тн/ | | |
|------|--------------|------------|----------------|------------|--------------|
| | | | Хадлан | Гар тэжээл | Эрдэс тэжээл |
| 2013 | 53 | 740 | 290.3 | 28.1 | - |
| 2014 | 59 | 835 | 505.5 | 88.7 | 70.4 |
| 2015 | 65 | 906 | 656.0 | 52.5 | 630.1 |
| Бүгд | 177 | 2481 | 1451.8 | 169.3 | 700.5 |

Эх сурвалж: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөөгийн амьжиргаа төсөл

Тайлант 2015 онд 3 сумын 11 малчны бүлгийн хадлангийн талбай сайжруулах саналыг дэмжиж хэрэгжүүлснээр 30 малчны бүлэгт 489 кг царгас, 100 кг эрдэнэшиш, 6200 кг овъёос, нийт 6789 кг нэг ба олон наст тэжээлийн ургамлын үр нийлүүлж 20,8 га талбайд тариалсан. Тариалалтын үр дүн нэмэгдүүлэх зорилгоор төслийн 3 суманд нийт 3 ш хөрс боловсруулах төхөөрөмж, 3 ш тэжээл няцлагч бутлагч, 12 ш 1 тн багтаамжтай ус нөөцлөх сав олгосон.

“Өвөлжөө, хаваржааны орчимд тэжээлийн ургамал тариалах”, “Орон нутгийн нөөцөөр дарш бэлтгэх” сургалт зохион байгуулж 333 хүн, үүнд 318 малчин хамруулснаар дараах үр дүн гарсан байна.Үүнд:

Төслийн сумдад бэлчээр, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлсэн мэдээ:

| Сумын нэр | Малчны бүлгийн тоо | Хашсан талбай | | Тэжээлийн ургамлын үр, кг | | | сан талбай, гаТариал | ХБТ | ТН | УНС |
|------------|--------------------|------------------------|-----------------------|---------------------------|------------|-------------|----------------------|-----|----|-----|
| | | Байгалийн хадлан хадах | Дэрст бэлчээр сэргээх | Царгас үр | Эрдэнэ шиш | Хошуу будаа | | | | |
| Бууцагаан | 20 | 4 | 3 | 330 | 60 | 4600 | 17,8 | 2 | 1 | 7 |
| Заг | 4 | - | 1 | 59 | - | 800 | 1,5 | 1 | 1 | 2 |
| Хүрээмарал | 6 | 2 | 1 | 100 | 40 | 800 | 1,7 | - | 1 | 3 |
| Нийт | 30 | 6 | 5 | 489 | 100 | 6200 | 21,0 | 3 | 3 | 12 |

Эх сурвалж: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөөгийн амьжиргаа төсөл

Төслийн 3 сумын 13 багийн 67 малчны бүлгийн 2015 оны бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх болон 74 бүлгийн 2016 оны бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд малчны бүлгүүдийн бэлтгэсэн өвс, тэжээлийн мэдээ авахад урьдчилсан байдлаар 65 бүлэг 656.0 тн өвс, 122650 ш зоодой, 6.1 тн өвсөн мушгиа, 630.1 тн хужир шүү, 80.1 тн сэвстэй хужрын долооц болон 45.8 тн дарш бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжснээс хойш давхардсан тоогоор 177 малчны бүлгийн 2481 өрхийн гишүүд 1451.8 тн хадлан, 169.3 гар тэжээл, 700.5 эрдэс тэжээл бэлтгэх нөхцлийг төслөөс бүрдүүлсэн байна.

Төслийн сумдын өвс, тэжээл бэлтгэлийн мэдээ:

| Сумын нэр | Малчны бүлгийн тоо | Өвс, тн | Зоодой, ш | Өвсөн мушгиа, тн | Хужир, тн | Сэвстэй хужрын долооц, тн | Дарш, тн |
|-------------|--------------------|--------------|---------------|------------------|--------------|---------------------------|-------------|
| Бууцагаан | 31 | 232,8 | 51750 | 3,9 | 240,5 | 41,8 | 25,6 |
| Заг | 18 | 194,0 | 27700 | 0,8 | 94,8 | 15,1 | 12,7 |
| Хүрээмарал | 16 | 229,2 | 43200 | 1,4 | 294,8 | 23,2 | 7,5 |
| Нийт | 65 | 656,0 | 122650 | 6,1 | 630,1 | 80,1 | 45,8 |

Эх сурвалж: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөөгийн амьжиргаа төсөл

4.4. БЭЛЧЭЭР САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ:

Бэлчээрт инженерийн хийцтэй болон гар худаг гаргах, усан сан, хөв цөөрөм байгуулах стандартыг боловсруулах: Улсын төсөв, орон нутаг, гадаадын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар гаргаж байгаа инженерийн хийцтэй худгийн ажлыг “Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага” MNS6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг улсын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Ус дутагдалтай бэлчээр нутагт усны хайгуул хийх, бэлчээрийн усан хангамжийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох арга хэмжээний хүрээнд: 2011-2014 онд 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймагт газрын доорхи усны геофизикийн хайгуулыг ажлыг 1891 бэлчээрт явуулж инженерийн хийцтэй шинэ худгийн 1300 гаруй устай цэгийг мэргэжлийн байгууллагаар тогтоон, мэдээллийн сан бүрдүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

Орон нутагт усан хангамжийг сайжруулах зорилгоор жил бүр 500-гаас доошгүй тооны инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, түүнд шаардагдах хөрөнгийн тодорхой хувийг хэрэглэгч-малчдаас гаргадаг болгох арга хэмжээний хүрээнд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013-2014 онд Солонгос улсад үйлдвэрлэсэн усны өрөмдлөгийн машин, компрессор, дагалдах хэрэгсэлийн хамт 8 иж бүрдлийг Баянхонгор, Завхан, Ховд, Увс, Хөвсгөл, Дундговь, Баян-Өлгий, Төв аймгуудад усны өрөмдлөгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд 5 хүртэл жилийн хугацаатай түрээсийн гэрээгээр олгож, түрээсийн төлбөрийг орон нутагтаа /худгийн гүнээс хамаарч худгийн тоо бага зэрэг өөрчлөгдөнө/ нийт 200 гаруй худаг гарган, эргэн төлөх нөхцөлтэйгөөр 5 хүртэлх жилийн хугацаатай олгож орон нутгийн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Төв, Дундговь аймгийн инженерийн хийцтэй 36 худагт нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн зарим сумдын инженерийн хийцтэй 36 худагт салхины эрчим хүчээр ажиллах ус өргүүрийг тус тус суурилуулж ашиглалтанд оруулсанаар малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсэн, өдөр тутмын ашиглалтын зардалгүй малаа услах боломжийг бүрдүүлсэн.

Худаг, уст цэгийн мэдээлэл:

| | | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|-----------------------------|-----------------|-------|-------|-------|-------|-------|
| Нийт уст цэгийн тоо | Инженер хийцтэй | 11737 | 15540 | 13173 | 12839 | 11151 |
| | Энгийн уурхайн | 27047 | 26535 | 27449 | 29722 | 29121 |
| | Усан сан | 643 | 1719 | 2084 | 1126 | 2008 |
| Шинээр гаргасан худаг | | 1245 | 1789 | 1151 | 1128 | 732 |
| Нийт худгийн тоо | | 40672 | 45583 | 43857 | 44815 | 43012 |
| Ашиглахад бэлэн худаг | | 36672 | 37517 | 39592 | 42805 | 40082 |
| Усаар хангагдсан өрх, мянга | | 170,9 | 167,8 | 160,6 | 166 | 145,9 |

Мэдээллийн эх сурвалж: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Улсын хэмжээнд 2012 онд 39.7, 2013 онд 42.7, 2014 онд 43.6, 2015 онд 42.3 мянган худаг байгаагаас ашиглахад бэлэн байгаа худаг 2012 онд 82 хувь, 2013 онд 90 хувь, 2014 онд 96 хувь, 2015 онд 93 хувь нь ашиглах боломжтой бөгөөд 145.9-170.9 мянган өрх усаар хангагдах нөхцлийг бүрдүүлсэн байна. Жил бүр Улс болон орон нутаг, гадаадын төсөл,

малчдын санаачлагаар усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр худаг гаргах ажлыг зохион байгуулсан.

Шинээр гаргасан худаг уст цэг:

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|-----------------------------|--------|---------|--------|---------|--------|
| Улсын төсвөөр | 527 | 463 | 408 | 439 | 15 |
| Санхүүжилт /сая.төг/ | 6907.5 | 6137.4 | 6254.7 | 7295.4 | 267.6 |
| Гадаадын төслөөр | 240 | 314 | 101 | 54 | 46 |
| Санхүүжилт /сая.төг/ | 2127.1 | 3791.9 | 1615.7 | 645.9 | 752.7 |
| Орон нутгийн хөрөнгөөр | 77 | 34 | 254 | 309 | 222 |
| Санхүүжилт /сая.төг/ | 258.9 | 169.9 | 2109.3 | 3357.0 | 2034.1 |
| Малчдын санаачлагаар | 401 | 978 | 388 | 326 | 449 |
| Шинээр гаргасан нийт худаг | 1245 | 1762 | 1151 | 1128 | 732 |
| Зарцуулсан зардал /сая.төг/ | 9293.5 | 10414.0 | 9979.7 | 11298.4 | 3054.4 |

Мэдээллийн эх сурвалж: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Үүний үр дүнд 2012 онд 1762, 2013 онд 1151, 2014 онд 1128, 2015 онд 732 худаг шинээр гаргасан.

Худаг шинээр гаргасан эх үүсвэрийн нийт зарцуулсан зардалд эзлэх хувь:

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|------------------------|------|------|------|------|------|
| Улсын төсвөөр | 42 | 26 | 35 | 39 | 2 |
| Гадаадын төслөөр | 19 | 18 | 9 | 5 | 6 |
| Орон нутгийн хөрөнгөөр | 6 | 2 | 22 | 27 | 30 |
| Малчдын санаачлагаар | 32 | 55 | 34 | 29 | 61 |

Мэдээллийн эх сурвалж: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төслийн санхүүжилтээр 46 худаг гаргахаас 53 худгийг шинээр гарган, 2 худгийг засварлаж, үүний үр дүнд 15 сумын 916 өрхийн 3173 хүн, 320.8 мянган толгой мал, 164252 га бэлчээрийг тус тус усаар хангах боломжийг бүрдүүлсэн байна. Үүнээс 2015 онд 19 худаг шинээр гаргаж 208 өрхийн 94757 толгой мал усаар хангагдаж 105030 га бэлчээрийг ашиглах боломжтой болсон байна.

“Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа” төслийн санхүүжилтээр гидрогеологийн суурь судалгааг 2013 онд 3 сумын 120 малчнаас асуулгын аргаар авч 54 цэгт маршрутын судалгаа хийж 44 цэгт худаг шинээр гаргах, 6 цэгт сэргээн засварлах боломжтой, 4 цэгт нь ус гарах магадлалгүйг тогтоосон. Төсөл хэрэгжснээс хойш 3 суманд шинээр 44 худаг, 9 худгийг сэргээн засварлаж, 44 гар худгийг сэргээн засварлаж, нийт 96 худаг уст цэгийг хэвийн ажиллах боломжоор хангасан байна.

Төслөөс гаргасан худаг:

| Он | Шинээр гаргасан худаг | Сэргээн засварласан худаг | Гар худгийг сэргээн засварлах | Бүгд |
|-------------|-----------------------|---------------------------|-------------------------------|-----------|
| 2013 | 28 | 4 | - | 32 |
| 2014 | 9 | 4 | 27 | 39 |
| 2015 | 7 | 1 | 17 | 25 |
| Нийт | 44 | 9 | 44 | 96 |

Мэдээллийн эх сурвалж: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөөгийн амьжиргаа төсөл

Цас, борооны усыг тогтоож, хөв цөөрөм байгуулах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр: “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл”-ийн хүрээнд 2013 онд 29, 2014 онд 24, 2015 онд 19, нийт 72 булаг шандны эхийг хашиж хамгаалах, ГовьАлтай аймгийн Алтай, Цогт, Цээл сумдад 6, архангай аймгийн өгийнуур суманд 1, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 1, нийт 8 хөвийг тус тус байгуулсан.

Өөрийн хөрөнгөөр гар худаг гаргах, усан сан байгуулах зэргээр малын усан хангамжийг сайжруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулан дэмжих арга хэмжээний хүрээнд: Орон нутагт малчид өөрийн хөрөнгөөр 2011 онд 401, 2012 онд 978, 2013 онд 388, 2014 онд 326, 2015 онд 449 гар худаг гаргаж ашигладтанд оруулж бэлчээрийн усан хангамжийн зориулалтаар ашиглаж байна. Аймгийн ХХААГ-ууд жил бүр гар худаг гаргах уралдааны болзол зарлаж шалгуур үзүүлэлтийг хангасан сум, баг болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөлд жил бүр аймгийн засаг даргын нөөцөөс 1.6 сая төгрөг, сумаас малчдаа 300-500 мянган төгрөгөөр урамшуулж байна.

Бэлчээрийн ашиглалт, кадастрын зураглалыг аймаг, сум тус бүрээр гаргах, мэдээллийн санг бий болгох арга хэмжээний хүрээнд: “Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа” төслөөс Баянхонгор аймгийн төслийн сумдад бэлчээр ашиглалтын гэрээ болон төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 74 малчны бүлгийн 67 бүлэг нь бэлчээр ашиглалтын гэрээтэй ажиллаж байна.

| Сумын нэр | Сумын малчны бүлгийн тоо | БАГ-тэй малчны бүлгийн тоо | БАГ-тэй бүлгийн хувь, % | БАГ-ээр ашиглаж буй бэлчээр, га | БАГ хэрэгжиж буй хувь, % |
|-------------|--------------------------|----------------------------|-------------------------|---------------------------------|--------------------------|
| Бууцагаан | 35 | 30 | 85,7 | 454100 | 77,8 |
| Заг | 21 | 19 | 90,5 | 216786 | 84,7 |
| Хүрээмарал | 18 | 18 | 100 | 314493 | 72,7 |
| Нийт | 74 | 67 | 90,5 | 985379 | 77,4 |

Мэдээллийн эх сурвалж: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөдөөгийн амьжиргаа төсөл

“Ногоон алт” төслийн хүрээнд аймаг, сумын түвшинд бэлчээр ашиглалтын холбоо (БАХ)-ны сүлжээ, бүтцийг байгуулан, төсөл хэрэгжиж буй 126 сумаас 90-д нь сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж, мөрдөн ажиллаж байна.

БАХ-д суурилсан бэлчээрийн менежментийн төлөвлөлт хэрэгжүүлж буй сумын тоо:

| Аймгууд | Сумын тоо | БАХ-д суурилсан бэлчээрийн менежментийн төлөвлөлт хэрэгжүүлж буй сумын тоо | | |
|------------|------------|--|-----------|-----------|
| | | 2013 | 2014 | 2015 |
| Архангай | 20 | 4 | 5 | 17 |
| Баянхонгор | 17 | 4 | 4 | 7 |
| Говь-Алтай | 18 | 11 | 11 | 11 |
| Ховд | 17 | 2 | 10 | 12 |
| Завхан | 23 | 12 | 16 | 22 |
| Увс | 18 | 9 | 13 | 9 |
| Баян-Өлгий | 13 | 12 | 12 | 12 |
| ДҮН | 126 | 41 | 71 | 90 |

Эх сурвалж: “Ногоон алт” төсөл

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төслөөс бэлчээрийн ашиглалт түүний төлөв байдлыг энгийн аргаар хянах боломжоор хангах үүднээс бэлчээр ашиглалтын нөлөөг фото зургаар баримтжуулан хянах аргыг төсөлд хамрагдаж буй Архангай, Хэнтий, Хөвсгөл, Говь-Алтай, Булган аймгийн 15 сумын газрын даамал, бэлчээрийн мэргэжилтэн, зарим сумдын цаг уурын ажилтан нийт 28 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан. Сургалтын дагуу 8 сард уг ажилтнууд нь фото мониторингийн аргаар бэлчээрийн үнэлгээг хийсэн болно. Нийт 15 сумын хөдөөгийн 66 багийн 228 цэгт фото зураг авч мэдээ мэдээллийг нэгтгэн сум тус бүр өөрсдийн тайланг боловсруулан сумын удирдлагад танилцуулж, мэдээллийн сан үүсгэсэн байна.

Сумдын тайлан мэдээнээс харахад үнэлгээ хийгдсэн нийт 66 багийн 54 багт бэлчээрийн даац хэтэрсэн, үүнээс 32 багт 1 дахин буюу түүнээс дээш даац хэтэрсэн дүнтэй гарчээ. Энэхүү арга нь орон нутгийн ажилтнууд өөрсдөө хийх боломжтой энгийн, зардал бага

зарцуулагдахын дээр фото зургаар баримтждаг тул дараа жил тухайн газраа дахин үнэлгээ хийж харьцуулах боломжийг бүрдүүлж байна.

Бэлчээрийн фото мониторинг хийсэн байдал:

| № | Сум | Бэлчээр /га/ | Нийт багийн тоо | Хамрагдсан багийн тоо | Цэгийн тоо | Даац хэтэрсэн багийн тоо | Үүнээс 1 дахин буюу түүнээс дээш даац хэтэрсэн багийн тоо |
|----|-------------------|----------------|-----------------|-----------------------|------------|--------------------------|---|
| | Архангай | 635969 | 15 | 14 | 42 | 19 | 15 |
| 1 | Өлзийт | 161847 | 4 | 4 | 14 | 12 | 8 |
| 2 | Батцэнгэл | 315238 | 6 | 6 | 18 | 3 | 3 |
| 3 | Өгийнуур | 158884 | 5 | 4 | 10 | 4 | 4 |
| | Булган | 492717 | 14 | 12 | 31 | 9 | 7 |
| 4 | Гурванбулаг | 214080 | 6 | 5 | 11 | 2 | 0 |
| 5 | Дашинчилэн | 206140 | 4 | 3 | 10 | 3 | 3 |
| 6 | Рашаант | 72497 | 4 | 4 | 10 | 4 | 4 |
| | Говь-Алтай | 2018421 | 15 | 14 | 45 | 5 | 2 |
| 7 | Цээл | 548085 | 4 | 4 | 15 | 0 | 0 |
| 8 | Цогт | 604112 | 7 | 7 | 15 | 5 | 2 |
| 9 | Алтай | 866224 | 4 | 3 | 15 | 0 | 0 |
| | Хөвсгөл | 1062107 | 19 | 19 | 60 | 17 | 6 |
| 10 | Бүрэнтогтох | 252058 | 6 | 6 | 29 | 2 | 0 |
| 11 | Цагаан-уул | 457489 | 6 | 6 | 15 | 15 | 6 |
| 12 | Цэцэрлэг | 352560 | 7 | 7 | 16 | 0 | 0 |
| | Хэнтий | 792515 | 12 | 7 | 50 | 4 | 2 |
| 13 | Цэнхэрмандал | 187057 | 4 | | 20 | | |
| 14 | Дархан | 409568 | 4 | 4 | 15 | 3 | 2 |
| 15 | Дэлгэрхаан | 195890 | 4 | 3 | 15 | 1 | 0 |
| | Нийт | 5001729 | 75 | 66 | 228 | 54 | 32 |

Эх сурвалж: "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент" төсөл

Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга, технологиор тэмцэх арга хэмжээний хүрээнд: Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээг жил бүр улсын төсвийн хөрөнгөөр 2 удаа буюу хавар, намрын улиралд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, мэргэжлийн хяналтын газар, сумын ЗДТГ болон мал эмнэлэг, үржлийн тасаг, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж байна.

Бэлчээрт хөнөөл учруулж буй хортон мэрэгчтэй 2010-2015 онд 647.8-747.5 мянган га талбайд энгийн механик болон биологийн аргаар тэмцэж, 1495.4-1709.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үлийн цагаан оготно, царцаатай тэмцсэн талбай, зарцуулсан зардал:

| | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|--|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Үлийн цагаан оготной тэмцсэн талбай /мян.га/ | 500.8 | 623.0 | 620.0 | 645.0 | 540.0 | 642.0 |
| Зарцуулсан хөрөнгө /сая.төг/ | 1209.5 | 1183.0 | 1184.0 | 1213.1 | 1069.4 | 946.4 |
| Царцаатай тэмцсэн талбай /мян.га/ | 147.0 | 111.5 | 123.1 | 102.5 | 112.5 | 102.5 |
| Зарцуулсан хөрөнгө /сая.төг/ | 500.0 | 574.8 | 483.2 | 394.4 | 426.0 | 549.0 |
| Тэмцсэн нийт талбай /мян.га/ | 647.8 | 734.5 | 743.1 | 747.5 | 652.5 | 744.5 |
| Зарцуулсан нийт хөрөнгө /сая.төг/ | 1709.5 | 1757.8 | 1667.2 | 1607.5 | 1495.4 | 1495.4 |

Мэдээллийн эх сурвалж: Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Энгийн механик болон биологийн аргаар тэмцсэнээр ажлын техникийн үр дүнгийн гүйцэтгэл 80-94 хувьтайгаар дүгнэгдэж, бэлчээр хамгаалах нөхцлийг бүрдүүлсэн.

Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна мал аж ахуйн салбарт хэрэгжиж буй гадаадын төслүүдийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төслийн хүрээнд энгийн механик аргаар хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг 17.5 сая төгрөгөөр 4533 ширхэг шувууны суудал, үүр босгох, 20-30 мянган үлийд ус цутгах, утах зэрэг аргуудыг 60 орчим мянган га талбайг хамруулан хийснээс ажлын үр дүн аймгуудын Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр дунджаар 88%-ийн биелэлтэйгээр хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

“Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа” төслөөс 2014 онд Бууцагаан сумын 25, Заг сумын 17, Хүрээмарал сумын 16 нийт 58 малчны бүлэг 720.0 мянган га бэлчээр чөлөөлж 252.9 мянган га бэлчээр өнжөөж сэлгэн нийт 972.9 мянган га бэлчээрт бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж сумдын Засаг даргын тамгын газартайгаа бэлчээр ашиглах гэрээг байгуулан ажилласан. Түүнчлэн 168 самбар, 400 суудал нэмж байрлуулах арга хэмжээг зохион байгуулсан.

4.5. МАЛЫН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ:

Монгол Улсын засгийн газар, Дэлхийн банктэй хамтран 2005 оноос эхлэн “Малын индексжүүлэлтийн даатгал” төслийг хэрэгжүүлж, улсын хэмжээний малчин өрхийг даатгалд хамруулах ажлыг эхлүүлэв.

Даатгалд хамрагдсан өрх, малын тоо:

| № | Үзүүлэлт | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|--------|--------|--------|--------|--------|------|
| 1 | Даатгуулсан өрхийн тоо | 6977 | 10910 | 15988 | 194447 | 14331 | |
| 2 | Мал бүхий өрхөд эзлэх хувь | 3,2 | 5,2 | 7,7 | 9,3 | 6,7 | |
| 3 | Даатгуулсан малын тоо, мян.тол | 1037,3 | 1553,9 | 2461,7 | 3491,2 | 3257,7 | |
| 4 | Оны эхний малд эзлэх хувь | 2,4 | 4,7 | 6,8 | 8,5 | 7,2 | |
| 5 | Даатгалд төлсөн хураамж, сая.төг | 416,1 | 847,3 | 1469,8 | 1799 | 1374 | |
| 6 | Даатгалаас олгосон нөхөн олговор, сая.төг | 108,3 | 112 | 278,9 | 40,5 | 0 | |

4.6. БЭЛТГЭХ ТЭЖЭЭЛИЙН ХЭМЖЭЭ:

Тэжээл үйлдвэрлэлийн хангамжийг сайжруулах зорилгоор 2013 онд 2-3 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай хүчит тэжээлийн 17 үйлдвэрийг 400.0 сая, ногоон тэжээлийн 15 үйлдвэрийг 500.0 сая, өвс хуйлж боох 45 техникийг 500.0 сая, нийт 1400.0 сая төгрөгийн худалдан авах ажлыг зохион байгуулан, иргэн аж ахуй нэгжид олгох арга хэмжээг хэрэгжүүлсэн.

УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Хүнс, хөдөө аж ахуйн талаар 2025 он хүртэл хугацаанд баримтлах бодлогод нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг бүсчилж хөгжүүлэх, малын тэжээл, био бордоо, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тэдгээрт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, нутагшуулах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мал бүхий иргэн, хуулийн этгээд, малчдад хөнгөлттэй нөхцөлөөр тоног төхөөрөмж олгож малын тэжээл үйлдвэрлэл, нийлүүлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлснээр өвс, хадлан бэлтгэх жижиг оврын техникийг 9 аймгийн 34 сумын нийт 978 иргэн, малчдад олгож, орон нутаг, өрхийн түвшинд бэлтгэх хадлан, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Тайлант 2015 онд урьдчилсан гүйцэтгэлээр байгалийн хадлан 1014.5 мян.тн, сүрэл 46.0 мян.тн, гар тэжээл 42.5 мян.тн, бэлтгэсэн дарш 3.2 мян.тн, эрдэс тэжээл 124.1 мянган тонныг тус тус бэлтгэсэн бөгөөд өмнөх жилүүдээс байгалийн хадлангаас бусад тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

Хадлан, тэжээл бэлтгэл, мян.тонноор:

| Тэжээлийн төрөл | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|--------------------------|--------|--------|--------|--------|--------|
| Байгалийн хадлан | 1195.2 | 1175.1 | 1169.3 | 1178.7 | 1014.5 |
| Сүрэл | 7.9 | 4.6 | 3.1 | 7.9 | 46.0 |
| Гар тэжээл | 46.7 | 39.1 | 36.6 | 40.3 | 42.5 |
| Бэлтгэсэн дарш | 8.5 | 2.1 | 3.9 | 4.0 | 3.2 |
| Эрдэс тэжээл | 40.4 | 36.6 | 31.8 | 38.1 | 124.1 |
| Үйлдвэрлэсэн тэжээл-бүгд | 663.2 | 624.6 | 609.8 | 614.0 | |

*-Урьдчилсан гүйцэтгэлээр статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуй 2014, Үндэсний

Үйлдвэрлэсэн тэжээлийн хангамжийн байдлыг авч үзвэл хонин толгойд шилжүүлснээр нэг хонинд 2011 онд 11, 2012 онд 9.3, 2013 онд 8.2, 2014 онд 7.1 кг-аар ногдож байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн хангамж:

| | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|---|------|------|------|------|-------|
| Хонин толгойд шилжүүлсэн мал, сая.тол | 60.2 | 67.3 | 74.8 | 86.2 | |
| Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг | 11.0 | 9.3 | 8.2 | 7.1 | |

*-Урьдчилсан байдлаар

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуй 2014, Үндэсний статистикийн хороо


Нэг хонинд ногдох хэмжээ 2012 онд 1.7, 2013 онд 1.1, 2014 онд 1.1 кг-аар тус тус буурсан байна.

Тав. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах зорилтын хүрээнд:

5.1. МАЛ НЯДАЛГААНЫ ЦЕХ БИЙ БОЛГОХ:

Улсын хэмжээнд мах нядалгааны анхан шатны 36 цех, үйл ажиллагаан явуулж байна. Үүнээс Улаанбаатар, Ховд аймагт 6, Архангай, Булган, Завхан, Орхон аймгуудад 3, Баян-Өлгий, Сэлэнгэ, Увс аймгуудад 2, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгуудад 1 цехтэй, Баянхонгор, ГовьАлтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь зэрэг аймгуудад 2015 оны жилийн эцсийн байдлаар мах нядалгааны цех байгууллагдаагүй байна.

МАЛ НЯДАЛГААНЫ ЦЕХИЙН ТОО



Эх сурвалж: Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Тайлант 2015 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 278 мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байгаагаас нийслэлд 146 үйлдвэр, цех буюу 52.5 хувь үйл ажиллагаа эрхэлж байна.

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ЦЕХИЙН ТОО



5.2-5.3. МАХ НЯДАЛГААНЫ ЖИНГЭЭР НИЙТ ҮЙЛДВЭРЛЭХ, СҮҮ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭ:

| | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* |
|--------------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Мах нядалгааны жингээр, мян.тн | 125,1 | 133,1 | 127,3 | 149,2 | 147,2 | 448.3 |
| Үхрийн | 47,5 | 53,6 | 59,7 | 57,7 | 54,7 | 93.2 |
| Хонины | 77,4 | 79,1 | 67,2 | 91 | 92 | 134.6 |
| Гахайны | 0,2 | 0,4 | 0,4 | 0,5 | 0,5 | |
| Сүү, мян.тн | 330,0 | 403,1 | 523,9 | 594,3 | 681,1 | 874.4 |
| Үнээний | 241,9 | 298,8 | 337 | 380,6 | 440,4 | 512.4 |
| Хонины | 39,6 | 33,4 | 64,5 | 74,2 | 84,7 | 95.2 |
| Ямааны | 48,5 | 70,9 | 122,4 | 139,5 | 156 | 172.6 |
| Өндөг /сая.ш/ | 53,6 | 69,4 | 56,6 | 63,2 | 72,2 | 74.3 |

*-Урьдчилсан байдлаар статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2014, Үндэсний

Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрүүдэд боловсруулсан үзүүлэлтээс үзэхэд угаасан ноос, үхрийн шир, хонины нэхий, ямааны нэхий боловсруулалт өссөн байна.

| Түүхий эд | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015* | Өөөрчлөлт | | | |
|--------------------------|------|------|------|------|-------|-----------|------|------|-------|
| | | | | | | 2012 | 2013 | 2014 | 2015* |
| Боловсруулсан мах, мян.т | 16 | 17 | 24 | 17 | | 0,2 | 7 | -6,8 | |
| Боловсруулсан сүү, сая.л | 43 | 53 | 50 | 72 | | 10 | -3 | 22 | |
| Угаасан ноос, т | 1845 | 1075 | 894 | 1387 | | -770 | -182 | 493 | |
| Самнасан ноос, т | 0 | 0 | 73 | 0 | | 0 | 73 | 0 | |
| Самнасан ноолуур, т | 874 | 417 | 513 | 633 | | -457 | 96 | 120 | |
| Үхрийн шир, ш | 45 | 63 | 54 | 92 | | 19 | -9 | 38 | |
| Хонины арьс, ш | 384 | 691 | 264 | 625 | | 307 | -426 | 361 | |
| Ямааны арьс, ш | 480 | 1184 | 895 | 1314 | | 704 | -289 | 419 | |

*-Урьдчилсан байдлаар статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2014, Үндэсний

Мал аж ахуйн бүтээгдэхүүний нэг хүнд ногдох хэмжээг харьцуулан үзэхэд мах 2012 онд 2.6, 2014 онд 10.4 кг-аар, сүү 2012 онд 16.9, 2013 онд 23, 2014 онд 28.2 кг-аар, өндөг 2013

онд 2, 2014 онд 2 ширхэгээр нэмэгдсэн, мах 2014 онд 3.8 кг-аар, өндөг 2012 онд 5 ширхэгээр тус тус буурсан байна.

Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн:

| Бүтээгдэхүүн | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | Өөрчлөлт | | | |
|-----------------------------|-------|-------|-------|-------|------|----------|------|------|------|
| | | | | | | 2012 | 2013 | 2014 | 2015 |
| Мах, нядалгааны жингээр, кг | 90,2 | 92,8 | 103,2 | 99,4 | | 2,6 | 10,4 | -3,8 | |
| Сүү, кг | 190,2 | 207,1 | 230,1 | 258,3 | | 16,9 | 23 | 28,2 | |
| Өндөг, ш | 25 | 20 | 22 | 24 | | -5 | 2 | 2 | |

*-Урьдчилсан байдлаар статистикийн хороо

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн 2014, Үндэсний

5.4. ДОТООДЫН ҮЙЛДВЭРҮҮДЭД НИЙЛҮҮЛСЭН, ГАРАЛ ҮҮСЭЛ НЬ ТОДОРХОЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ЧАНАРААС ХАМААРАН УРАМШУУЛАЛ ОЛГОХ:

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эдийн засгийн урамшуулал бий болгосон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд: Монгол Улсын Их Хурлын 30 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай” журмын дагуу урамшууллыг Мал хамгаалах сан, Монгол банкаар дамжуулан малчдын дансанд шууд шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Хөтөлбөрийн эхний шат буюу 2011- 2014 онуудад үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноосоо тушаасан 334.4 мянган /давхардсан тоогоор/ малчин, мал бүхий иргэдийн 54.5 тонн ноосонд нийт 94.1 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон.


Ноосны урамшуулал:

| Он | Малчны тоо | Ноосны хэмжээ /кг/ | Мөнгөн дүн /төгрөг/ |
|------------|----------------|---------------------|-----------------------|
| 2011 | 32.977 | 4,924,966.40 | 9,849,932,924 |
| 2012 | 103.162 | 14,695,624.7 | 29,391,249,152 |
| 2013 | 117.667 | 18.307.338,2 | 36,614,676,400 |
| 2014 | 80.619 | 16,643,479.3 | 18,293,838,780 |
| ДҮН | 334.425 | 54,571,408.6 | 94,149,697,256 |

Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан

Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу ноосны урамшууллыг ноосны чанар, үүлдэрлэг байдлаас хамааран ялгавартайгаар олгодог болсон ба хонины нарийн, нарийвтар ноос болон тэмээний ноосонд 2000 төгрөгөөр бодож 7634 хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэний бэлтгэсэн 1.75 мянган тонн ноосны 1.7 тэрбум төгрөгийг Монголбанк дахь Мал хамгаалах сангийн “Малчин” дансанд байршуулж малчдын арилжааны банк дахь дансны мэдээллийг шалгаж, шилжүүлээд байна.

2011-2014 ОНД ОЛГОСОН НООСНЫ УРАМШУУЛАЛЫН МӨНГӨН ДҮН



Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан

Улсын Их Хурлын 2013 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30 өдрийн 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам”-ын хүрээнд 2013 оны сүүлийн хагас жил болон 2014 оны эхний хагас жилд үндэсний боловсруулах үйлдвэрт түүхий эд тушаасан малчин, мал бүхий этгээдэд дараах урамшууллыг олгоод байна.


Арьс, ширний урамшуулал:

| Он | Малчны тоо | Арьс, ширний тоо /ширхэг/ | | Олгосон мөнгөн дүн /тэрбум.төг |
|----------------------|--------------|---------------------------|---------------|--------------------------------|
| | | Бод | Бог | |
| 2013 /сүүлийн хагас/ | 29811 | 40620 | 700297 | 2,7 |
| 2014 /эхний хагас/ | 3082 | 3806 | 54184 | 0,219 |
| Дүн | 32893 | 44426 | 754481 | 2,919 |

Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан

Тайлант 2015 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-110 дугаар тушаалаар 21 аймаг, нийслэлийн 54535 хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн үндэсний үйлдвэрт тушаасан 1854943 ширхэг бог, 159654 ширхэг бод, нийт 2014597 ширхэг арьс ширэнд 7959.6 сая төгрөгийн урамшууллын санхүүжилтийг Монголбанкн дахь “Малчин” дансанд байршуулж малчдын арилжааны банкин дахь дансанд шилжүүлээд байна.

2011-2014 ОНД ОЛГОСОН АРЬС, ШИРНИЙ УРАМШУУЛАЛД ОЛГОСОН МӨНГӨН ДҮН



Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан

5.5. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН СҮЛЖЭЭ БИЙ БОЛГОХ:

Биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах зорилготой орон тооны бус биржийн зохицуулах зөвлөлийг Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 188 дугаар тогтоолоор байгуулж, зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг батлуулав.

Биржийн сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, хичээл боловсруулан АХБ-ны ХАА, Хөдөөгийн хөгжлийн төсөл болон аймгуудын ХХААЖДҮГ-тай хамтран Архангай, Завхан, Говь-Алтай, Дундговь, Булган, Хөвсгөл, Орхон, Өмнөговь, Хэнтий, Өвөрхангай, Дархан-Уул, Ховд, Дорнод зэрэг 13 аймагт биржийн арилжаанд оролцогчдыг сургах сургагч-багш бэлтгэх сургалтуудыг зохион байгууллаа. Сургалтаар биржийн тухай хууль тогтоомж, бирж байгуулах бэлтгэл ажлын явц, биржийн тухай ойлголт, арилжаа, төлбөр тооцоо, ноос, ноолуур, улаан буудай, арьс ширний бэлтгэл, стандарт болон агуулах, тээврийн аж ахуйн талаар мэдээлэл өгч, шалгалтад тэнцсэн 228 сумын захиргааны 431 дарга, мэргэжилтэнд “Биржийн сургагч-багш”-ийн сертификат олгосон.

Хөдөө аж ахуйн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, бараа, түүхий эдийн хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн техник, эдийн засгийн үндэслэл, Биржийн үйл ажиллагаатай холбоотой нийт 12 журмын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулав.

Засгийн газрын 2013 оны 30 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” Төрийн өмчит хуулийн этгээд байгуулагдаж, Төрийн өмчийн хорооны 2013 оны 40 дүгээр тогтоолоор компаний дүрэм, бүтцийг батлан 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлсэн.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 03 сарын 07-ны өдрийн А/35 тоот тушаалаар биржээр Хонины ноос, ноолуур арилжих тухай “Бараа, түүхий эдийн жагсаалт, ангилалын код”, “Бараа түүхий эдийг коджуулах журам”-ыг батлан, ҮХАА-н сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/135 дугаар тушаалаар биржээр арилжих барааны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хүнсний буудай болон тосны ургамал /рапс/, малыг биржээр арилжих барааны жагсаалтанд оруулан батлуулж, Хүнсний буудай, амьд мал биржээр арилжиж байна.

Биржээр арилжаа /2013-2015 он/:

| Бараа | 2013 | 2014 | 2015 |
|--------------------------|--------|--------|---------|
| Ямааны ноолуур /тн/ | 6382,1 | 6123,7 | 6877,0 |
| Хонины ноос /тн/ | 1005,4 | 7641,3 | 10710,8 |
| Тэмээний ноос /тн/ | 1048,0 | 1025,6 | 433,9 |
| Ямааны завод ноос /тн/ | - | 1546,2 | 1954,8 |
| Тэмээний завод ноос /тн/ | - | 24,0 | 19,0 |
| Хонины завод ноос /тн/ | - | 878,3 | 699,6 |
| Тосны ургамал /тн/ | 14,912 | 12,535 | - |
| Амьд хонь /толгой/ | - | 12,0 | - |
| Хүнсний буудай /тн/ | - | - | 1576,0 |

Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж


Хөдөө аж ахуйн биржээр 2013-2015 онд 19382.8 тн ямааны ноолуур, 19357.5 тн хонины ноос, 2507.5 тн тэмээний ноос, 3501.1 тн ямааны завод ноос, 43.0 тн тэмээний завод ноос, 1577.9 тн хонины завод ноос, 27.4 тн тосны ургамал, 12 толгой хонь, 1576.0 тн хүнсний буудай тус тус арилжаалагдсан байна.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ:

Монгол улсын их хурлын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дахь заалтад “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 3 хувиас багагүй байхаар тооцож жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, хөрөнгийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хөдөө аж ахуйн хоршоог түшиглэн хэрэгжүүлэхээр баталсан.

Улсын их хурлын 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 64 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлах тухай ” Улсын Их Хурлын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй тооцсон байна.

"МОНГОЛ МАЛ" ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ



Хөтөлбөрийн санхүүжилтийг урьдчилсан мэдээгээр нийт 273.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

ТАВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮНГИЙН ХҮРСЭН ТҮВШИН

Хөтөлбөрийн дунд шатны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ:

“Монгол мал” хөтөлбөрийн 2010-2015 оны дунд шатны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг, хүрсэн түвшинтэй харьцуулах, Засгийн газрын 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын үнэлгээний аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний товчоо:

| № | Тэргүүлэх чиглэл | Үнэлгээний хувь | | | | | | | | | |
|------------|--|-----------------|-----------|-----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 16 | 15 | 14 | 10 | 0 |
| 1 | Салбарын эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангах, мал аж ахуйн салбарт сайн засаглалыг хөгжүүлэх | - | 1 | 4 | - | - | - | - | - | - | - |
| 2 | Малын үржлийн ажил, үйлчилгээг боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх | 2 | 6 | 3 | 4 | 1 | - | - | - | - | |
| 3 | Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах | - | 1 | 7 | 4 | 1 | - | - | - | 1 | |
| 4 | Уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрсдэл даах чадавхийг сайжруулах | 3 | 1 | - | 1 | 1 | - | - | 1 | 1 | |
| 5 | Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах | 3 | 2 | - | - | - | 1 | 1 | - | - | |
| ДҮН | | 8 | 11 | 14 | 5 | 3 | 1 | 1 | 1 | - | 2 |

Шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинд хүрсэн байдлыг үнэлэхэд 8 шалгуур үзүүлэлт 100 хувьтай, 11 шалгуур үзүүлэлт 90 хувьтай, 14 шалгуур үзүүлэлт 70 хувьтай, 5 шалгуур

үзүүлэлт 50 хувьтай, 3 шалгуур үзүүлэлт 30 хувьтай, 3 шалгуур үзүүлэлт 14-16 хувьтайгаар үнэлэгдэв. Шалгуур үзүүлэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 67.8 хувьтайгаар үнэлэгдэж байна.

Хөтөлбөрийн дунд шатны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ:

| Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | 2008 оны түвшин | 2015 онд хүрэх түвшин | 2010-2015 онд хүрсэн түвшин | Үнэлгээ |
|--|------------------------------|-----------------|-----------------------|-----------------------------|-------------|
| 1. Нэгдүгээр тэргүүлэх чиглэл: Салбарын эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангах, мал аж ахуйн салбарт сайн засаглалыг хөгжүүлэх: | | | | | |
| 1.1. Мал аж ахуйн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | | | | 70.0 |
| Төрийн үйлчилгээний алба | тоо | 0 | 332 | 332 | 70.0 |
| Хувийн хэвшлийн үйлчилгээний нэгж (шинээр) | тоо | 751 | 75 | 960 | 70.0 |
| 1.3. Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх: | | | | | |
| Шинээр давтан сургасан мэргэжилтэн | тоо, өссөн дүнгээр | 104 | 1908 | 16132 | 90.0 |
| Малчны түр сургууль төгсөгчид | тоо, өссөн дүнгээр | 25 | 10200 | 8375 | 70.0 |
| Дундаж үнэлгээ | | | | | 74.0 |
| 2. Хоёрдугаар тэргүүлэх чиглэл: Малын үржлийн ажил, үйлчилгээг боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх: | | | | | |
| 2.1. Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд: | | | | | |
| Малын удмын сангийн үндэсний цогцолбор | тоо | 0 | 1 | 1 | 80.0 |
| Бүсүүдэд байгуулагдсан мал үржүүлэг, биотехнологийн салбар | тоо | 0 | 2 | 1 | 50.0 |
| Зохиомлоор хээлтүүлэх мал | тоо, өссөн дүнгээр | 3200 | 24000 | 97207 | 70.0 |
| 2.2. Дотооддоо үйлдвэрлэх, импортоор авах үржүүлгийн бүтээгдэхүүн: | | | | | |
| Дотооддоо үйлдвэрлэсэн үр | тоо, өссөн дүнгээр | 21000 | 60000 | 32252 | 54.0 |
| Импортлосон үр, хөврөл үр | тоо, өссөн дүнгээр | 7000 | 30000 | 49727 | 70.0 |
| 2.3. Оны эхний малын тоо | мян.тол | 43288.0 | 35298.9 | 55957.6 | 90.0 |
| үүнээс: төрөл тус бүрээр: | | | | | |
| тэмээ | хувь | 0.6 | 0.8 | 0.7 | 90.0 |
| адуу | хувь | 5.1 | 6.8 | 5.9 | 90.0 |
| үхэр | хувь | 5.8 | 9.6 | 6.8 | 90.0 |
| хонь | хувь | 42.4 | 45.4 | 44.6 | 90.0 |
| ямаа | хувь | 46.1 | 37.4 | 42.1 | 90.0 |
| 2.4. Нэг малаас авах ашиг шим: | | | | | |
| Цэвэр, эрлийз үнээний сүү | 305 хоног/кг | 1769 | 2673 | 2025 | 70.0 |
| Ноолуур | грамм | 290 | 300 | 350 | 100 |
| Нарийн, нарийвтар ноос | кг | 3.9 | 4.4 | 2.7 | 50.0 |
| Бүдүүн, бүдүүвтэр ноос | кг | 1.1 | 1.3 | 1.4 | 100 |
| 2.5. Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох: | | | | | |
| Сүлжээнд хамрагдсан нэгж | тоо | 0 | - | 302 | 50.0 |
| Бүртгэлжүүлэх мал, өссөн дүнгээр | хувь | 0.3 | 60.0 | 15.2 | 30.0 |
| Дундаж үнэлгээ | | | | | 74.3 |
| 3. Гуравдугаар тэргүүлэх чиглэл: Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах: | | | | | |
| 3.1. Монгол Улс дараахь өвчнөөр тайван, өвчингүй статусыг ДМАЭМБ-аас авах: | | | | | |
| Үхрийн цээж | | - | сертификат | - | 50.0 |
| Үхрийн тархины эд сархиатах | | - | - | - | 50.0 |
| Шүлхий | | - | - | - | 50.0 |
| Хонь, ямааны цэцэг | | - | - | - | 50.0 |
| 3.2. Малыг дараахь төрлийн өвчнөөс эрүүлжүүлэх: | | | | | |
| Үхэр, тэмээг бруцеллөз өвчнөөс | хувь | 98.0 | 100 | | 70.0 |
| Адууг ям өвчнөөс | хувь | 97.5 | 100 | | 70.0 |
| Халдварт цус багасах өвчнөөс | хувь | 99.3 | 100 | | 70.0 |
| Сүүний үхрийг лейкоз өвчнөөс | хувь | 75.0 | 100 | | 70.0 |
| Бог малыг бруцеллөз өвчнөөс | хувь | 99.5 | 99.7 | | 70.0 |

| | | | | | |
|---|---|-------|-------|--------|-------------|
| Бруцеллёзоос тайван бус нийт малчин өрх /одоо 3,5-11,7 хувь/ | хувь | 7.6 | 0.3 | | 70.0 |
| 3.3. Малын гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байх: | <p>Малын гоц халдварт шүлхий өвчин 2000, 2001, 2002, 2004, 2005, 2006, 2010, 2014, 2015 онуудад тус тус оношлогдож, тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>Шүлхий өвчин 2015 онд Сүхбаатар, Баян-Өлгий, Ховд аймгийн нэр бүхий 5 суманд 9 удаагийн голомтоор гарч 1024 мал өвчилж, 90 толгой малыг устгасан.</p> <p>Манай оронд хонь ямааны цэцэг өвчин 1967, 1977 онуудад бүртгэгдэж, түүнээс хойш тайван байж байгаад 2006 оны 11 сард Сүхбаатар аймгийн Асгат, Баруун урт сумдад анх оношлогдож 2006-2007 онд нийт 7 сумын 14 голомтонд 978 хонь өвчилсөн байна. Ямааны цэцэг өвчин 2008 онд Дорнод аймгийн Хэрлэн, Баянт үмэн сумдад оношлогдож, нийт 423 ямаа өвчилсөн бүртгэгдсэн. Хонины цэцэг өвчин 2013 оны 1 дүгээр сард Дорнод аймгийн Хатанбулаг суманд оношлогдож тэмцэх зааврын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Хонины цэцэг өвчин 2015 онд Дорнод аймгийн Баянтүмэн суманд анх оношлогдож улмаар хил залгаа Сүхбаатар, Хэнтий, Дорноговь аймгийн 22 сумын нутаг дэвсгэрт халдварлаж нийтдээ 54 удаагийн голомтоор 1431 толгой мал, амьтан өвчилж 78 толгой малыг зааврын дагуу устгасан.</p> | | | | |
| 3.4. Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхитай болох: | лабораторийн тоо | 120 | 106 | 55 | 30.0 |
| 3.5. Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох: | тоо | 0 | - | 5 | 70.0 |
| 3.6. Малын эм, биобэлдмэл /вакцин, оношлуур/-ийг дотооддоо үйлдвэрлэх: | хувь | 70 | 85 | 90.0 | 90.0 |
| Дундаж үнэлгээ | | | | | 57.8 |
| 4. Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл: Уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрсдэл даах чадавхийг сайжруулах: | | | | | |
| 4.1. Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээ: | хувь | 0.5 | 5.0 | 0.7 | 14.0 |
| 4.2. Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулан малын тооны дээд хязгаарыг /квот /тогтоох: | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | | | | 0 |
| 4.3. Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох: | тоо | 38 | 150 | 64 | 30.0 |
| 4.4. Бэлчээр сайжруулах арга хэмжээ: | | | | | |
| Шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийн тоо | тоо | 1314 | 3600 | 6045 | 100 |
| Бэлчээрийн хортон, мэрэгч амьтантай тэмцсэн талбай | мян.га, өссөн дүнгээр | 700 | 3000 | 4269.9 | 100 |
| 4.5. Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох: | | | | | |
| Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо | хувь, өссөн | 3.3 | 15 | 6.7* | 50.0 |
| 4.6. Бэлтгэх тэжээлийн хэмжээ: | | | | | |
| Нийт үйлдвэрлэсэн тэжээл | тэж.нэгж, мян. тн, өссөн дүнгээр | 560.5 | 700.0 | 614* | 90.0 |
| Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээл | хувь, өссөн | 9.6 | 30 | 30 | 100 |
| Дундаж үнэлгээ | | | | | 60.5 |
| 5.Тавдугаар тэргүүлэх чиглэл: Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах: | | | | | |
| 5.1.Мал нядалгааны цех бий болгох | тоо, өссөн дүнгээр | 25 | - | 36 | 70 |
| 5.2. Мах, нядалгааны жингээр нийт үйлдвэрлэсэн махны хэмжээ: | | | | | |
| Үүнээс: | мян.тн | 223.1 | 353.8 | 448.3 | 100 |
| үйлдвэрийн аргаар боловсруулсан | мян.тн | 15.1 | 70.8 | 11.7 | 16.0 |
| экспортод гаргасан | мян. тн | 10.2 | 33.0 | 4.9 | 15.0 |
| 5.3. Нийт үйлдвэрлэсэн сүүний хэмжээ: | | | | | |
| Үүнээс: | мян.тн | 457.3 | 523.8 | 874.4 | 100 |

| Үйлдвэрийн аргаар боловсруулсан | мян.тн | 16.5 | 52.4 | 70.3 | 100 |
|--|--|------|------|------|-------------|
| 5.4. Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олголт | Хөтөлбөрийн эхний шат буюу 2011- 2014 онуудад үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноосоо тушаасан 334.4 мянган /давхардсан тоогоор/ малчин, мал бүхий иргэдийн 54.5 тонн ноосонд нийт 94.1 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон. Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу ноосны урамшууллыг ноосны чанар, үүлдэрлэг байдлаас хамааран ялгавартайгаар олгодог болсон ба хонины нарийн, нарийвтар ноос болон тэмээний ноосонд 2000 төгрөгөөр бодож 7634 хоршооны гишүүн малчин, мал бүхий иргэний бэлтгэсэн 1.75 мянган тонн ноосны 1.7 тэрбум төгрөгийг Монголбанк дахь Мал хамгаалах сангийн “Малчин” дансанд байршуулж малчдын арилжааны банк дахь дансны мэдээллийг шалгаж, шилжүүлээд байна. Улсын Их Хурлын 2013 оны 74 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30 өдрийн 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журам”-ын хүрээнд 2013 оны сүүлийн хагас жил болон 2014 оны эхний хагас жилд үндэсний боловсруулах үйлдвэрт түүхий эд тушаасан малчин, мал бүхий этгээдэд дараах урамшууллыг олгоод байна. Тайлант 2015 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-110 дугаар тушаалаар 21 аймаг, нийслэлийн 54535 хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн үндэсний үйлдвэрт тушаасан 1854943 ширхэг бог, 159654 ширхэг бод, нийт 2014597 ширхэг арьс ширэнд 7959.6 сая төгрөгийн урамшууллын санхүүжилтийг Монголбанк дахь “Малчин” дансанд байршуулж малчдын арилжааны банкин дахь дансанд шилжүүлээд байна. | 90.0 | | | |
| 5.5. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох | Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 03 сарын 07-ны өдрийн А/35 тоот тушаалаар биржээр Хонины ноос, ноолуур арилжих тухай “Бараа, түүхий эдийн жагсаалт, ангилалын код”, “Бараа түүхий эдийг коджуулах журам”-ыг батлан, ҮХАА-н сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/135 дугаар тушаалаар биржээр арилжих барааны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, хүнсний буудай болон тосны ургамал /рапс/, малыг биржээр арилжих барааны жагсаалтанд оруулан батлуулж, Хүнсний буудай, амьд мал биржээр арилжиж байна. | 90.0 | | | |
| Дундаж үнэлгээ | | | | | 72.6 |
| Дундаж үнэлгээ | | | | | 67.8 |

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх 5 тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлттээс 2 нь хүрэх түвшиндээ хараахан хүрсэнгүй. Шалгуур үзүүлэлтийн 2015 онд хүрсэн түвшингийн үзүүлэлтийг суурь он буюу 2008 оны үзүүлэлттэй харьцуулахад ихэнх үзүүлэлт өссөн дүнтэй байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс дараах 11 арга хэмжээ удаашралтай хэрэгжсэн байна. Удаашралтай хэрэгжиж буй шалтгаан нь хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний санхүүжилттээс хамаарсан гэж дүгнэж байна.

Удаашралтай хэрэгжиж буй арга хэмжээ:

| № | Арга хэмжээ |
|---|---|
| Мал аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | |
| 1 | 1.1.1. Бэлчээрийн тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх |
| 2 | 1.1.8. Малын эмч, мал зүйч нарыг мэргэжлээс шалтгаалах өвчний болон хүнд нөхцөлд ажиллаж байгаа бүлэгт хамруулах эрх зүйн орчинг бий болгох |
| 3 | 1.3.3. Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологийн болон инновацийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх |
| Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг | |
| 4 | 2.1.1. Цөм сүргийн малыг үржүүлж, чанар, стандартын шаардлага хангасан үр, хөврөл үр үйлдвэрлэх үүсгэл санаачилгыг дэмжих |
| 5 | 2.1.2. Монголд үржүүлж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийн түвшинг судлан тогтоож, зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржил-селекцийн ажил зохион байгуулах |
| 6 | 2.2.1. Малын удмын сангийн үндэсний цогцолборыг байгуулах асуудлыг судлах |
| 7 | 2.4.4. Мал аж ахуй эрхэлж байгаа малчин өрх, байгууллагын мал эмнэлэг, үржлийн ажлын анхан шатны бүртгэл, бүтээгдэхүүний гарал, үүслийг тодорхойлох стандарт боловсруулах |
| Байгалийн эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх | |
| 8 | 4.1.6. Аймаг дундын болон сум дундын отрын бүс нутгийг шинээр бий болгох, |
| Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | |
| 9 | 5.1.5. Малын дайвар бүтээгдэхүүний судалгааг гаргаж, ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах |
| 10 | 5.1.7. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх |
| 11 | 5.3.7. Малын паразиттах өвчнийг эмчлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийг технологийн дагуу хамруулж, үр дүнг нь бэлэн бүтээгдэхүүний чанараар тодорхойлдог тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэн нэвтрүүлэх |

Төлөвлөгөөнөөс 11 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Тасарсан шалтгаан нь хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлээгүй байна.

Хэрэгжээгүй арга хэмжээ:

| № | Арга хэмжээ |
|---|---|
| Мал аж ахуйн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | |
| 1 | 1.2.5. Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын талаархи мэдээллийн нэгдсэн сүлжээ, сан бий болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулах |
| 2 | 1.3.4. Мал эмнэлэг, үржлийн загвар аж ахуй, мэргэжлийн баг, нэгж бий болгож, шинжлэх ухааны ололт, инноваци үйлдвэрлэлд нэвтрүүлэх |
| Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг | |
| 3 | 2.2.3. Улсын хилээр үржлийн мал амьтан, тэдгээрийн үр, хөврөл үр, өндгөн эсийг нэвтрүүлэх ажлыг нэгдсэн бүртгэл, хяналттай болгох |
| 4 | 2.4.1. Мал сүргийг бүртгэх ажлыг цөм сүргээс эхлэн үе шаттай хэрэгжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ бий болгох асуудлыг судлан шийдвэрлэх |
| Малын эрүүл мэндийг хамгаалах | |
| 5 | 3.1.9. Орон нутгийн эндемик өвчнүүдээс мал сүргийг хамгаалах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх |
| 6 | 3.2.2. Сум дундын мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний явуулын лаборатори байгуулах |
| 7 | 3.2.3. Мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг сумын түвшнээс эхлэн олон улсын стандарт, арга зүйн дагуу гүйцэтгүүлэх |
| Байгалийн эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх | |
| 8 | 4.1.1. Бэлчээрийн ашиглалт, кадастрын зураглалыг аймаг, сум тус бүрээр гаргах, мэдээллийн санг бий болгох |
| Мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох | |
| 9 | 5.1.3. Сум бүрт мал нядалгааны болон арьс ширний анхан шатны цехийг байгуулах ажлыг жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хүрээнд дэмжих |
| 10 | 5.1.4. Мал, мах бэлтгэл болон технологийн тээвэр бүхий борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгох |
| 11 | 5.2.2. Стандартад заасан ангилал, зэрэглэлийн дагуу түүхий эдэд ялгавартай үнэ тогтоох арга хэмжээ авах |

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 67.8 хувьтай буюу “Хангалттай” гэж үнэлэгдэж байна. Үүнээс нэг дүгээр тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.0 хувьтай, хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.3 хувьтай, гуравдугаар тэргүүлэх чиглэл 57.8 хувьтай, дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл 60.5 хувьтай, тавдугаар тэргүүлэх чиглэл 72.6 хувийн биелэлттэй байна. Уг хөтөлбөр нь 2021 он хүртэл үргэлжлэх бөгөөд хэрэгжилт удаашралтай болон хэрэгжээгүй арга хэмжээг 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 11 арга хэмжээ удаашралтай хэрэгжиж, 11 арга хэмжээгүй байна.

3. Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин болох 2008 оны үзүүлэлттэй 2015 оны хүрсэн түвшинг харьцуулахад өссөн дүнтэй байна.

4. Хөтөлбөрийн “Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах” гуравдугаар тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтээр үр дүн, үр нөлөөг тооцон үнэлэх боломжгүй байна.

5. Тус хөтөлбөрийн нэгдсэн төсөв байхгүй, зарцуулсан зардлын тайлан, үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлагналт хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүн, үр дагаврын үнэлгээ, дүгнэлт өгөхөд хүндрэл учруулж байна.

6. Аймаг, нийслэлийн түвшинд батлагдсан дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийн үр дүн хөтөлбөрийн үндсэн тайланд тусгагдахгүй байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

- ✓ “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёрдугаар үе шатанд /2016-2021 он/ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, батлуулах;
- ✓ Хөтөлбөрийн эхний шатанд удаашралтай болон хэрэгжээгүй арга хэмжээг хоёрдугаар шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллах;
- ✓ Хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хөтөлбөрийн “Удирдах хороо”-гоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах;
- ✓ Хөтөлбөрийн “Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах” гуравдугаар тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг үр дүн, үр нөлөөг тооцож болохуйц шалгуур үзүүлэлтээр шинэчлэх;
- ✓ Хөтөлбөрийн хоёрдугаар шатны нэгдсэн төсвийг батлуулж, зарцуулсан зардлын тайлан, үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээ тус бүрээр суурь түвшин, зорилтот түвшин, хүрсэн түвшингөөр үр дүн, үр нөлөөллийг дүгнэсэн байдлаар тайлагнахад анхаарч ажиллах;
- ✓ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг ЗГХЭГ-т хүргүүлэх тул ХШҮДАГ-аас тогтоосон хугацаанд тайлан мэдээг ирүүлж байхыг зөвлөж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ